



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/100/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn Аудитор: Б.Батхишиг Утас: 261628 Цахим хаяг: Batkhishigb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	14
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	16
3.4.1 Мөнгөн хөрөнгө данс	17
3.4.2 Авлага данс.....	18
3.4.3 Урьдчилгаа данс.....	19
3.4.4 Бараа материал данс.....	19
3.4.5 Үндсэн хөрөнгө данс.....	19
3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт данс.....	20
3.4.7 Бусад эргэлтийн бус хөрөнгө данс	20
3.4.8 Өр төлбөр данс.....	21
3.4.9 Эздийн өмч данс.....	21
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	21
4. АУДИТЫН ТАЙЛАН	25
4.1 Ерөнхий зүйл	25
4.2 Материаллаг байдал	25
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	25
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	25
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	26
4.4.1.1 Албан шаардлага	26
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	26
4.4.2.1 Албан шаардлага	26
4.4.2.2 Зөвлөмж	30
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	32
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	35
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа.....	35
5.1.1 Залруулсан алдаа.....	35
5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил.....	35
5.2.1 Төлбөрийн акт	35
5.2.2 Албан шаардлага.....	36
5.2.3 Зөвлөмж.....	43
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	50

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИХ	Монгол Улсын Их Хурал
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОХУ	Оросын Холбооны Улс
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
ҮЦК	Үнэт цаасны компани
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАВААДАЛАЙ
ТАНАА

2026.03.16 № 732

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 43,986.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эрдэнэс Монгол ХХК нь 2011 оноос хойш 11 охин, 1 хараат компанид нийт 142,414.4 сая төгрөг, тайлант онд нэмж 6 компанид 18,666.1 сая төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон нь зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж, насжилт өндөртэй найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн;
- Тайлант хугацаанд охин болон хараат компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн гэрээний хугацаа дууссан байхад зээлийн үндсэн төлбөр 15,540.2 сая төгрөг, хуримтлагдсан хүү 1,061.2 сая төгрөг, нийт 16,601.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээг аваагүй;
- Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлахтай холбоотой ажлаас чөлөөлөгдсөн 4 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 111.1 сая төгрөгийг компаниас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан

тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, тайлант онд нэмж 8 ажилтанд 350.9 сая төгрөг нийт 462.0 сая төгрөгийг компаниас олгож, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй;

- Эрдэнэс Ассет Менежмент ҮЦК ХХК-ийг 2023 онд татан буулгаж, тус байгууллагаас авах 1,700.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй, авлагыг барагдуулаагүй байхад хуримтлагдсан ашиг дансанд хааж бүртгэсэн;
- Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн эзэмшлийн MV-13311, MV-13312 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг ашиглуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт бүрдээгүй, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад 2009 оноос эхлэн Шивээ Овоо ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээг жил бүр сунган тус талбайд нүүрс олборлуулсаар байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Компанийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3, 27.10, 84 дүгээр зүйлийн 84.4.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2.9, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2, Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 32.6 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулан тогтоож, 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Зөвч Овоо, Дулаан Уулын ордуудын техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулсан байна.

Дээрх ордуудыг ашиглахтай холбоотой Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан Бадрах Энержи ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан байна. Бадрах Энержи ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10.0 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулахаар тогтоосон байна.

Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоол болон Засгийн газрын 2025 оны 154 дүгээр тогтоолоор Зэс боловсруулах цогцолбор ХХК-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр үүсгэн байгуулсан байна.

Засгийн газрын 2024 оны 223 дугаар тогтоол, Эрдэнэс монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 15 дугаар тогтоолоор Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн менежментийн хэрэгжилтийн бэлтгэлийг хангах, сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодод сурталчлан таниулах чиг үүрэг бүхий Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийг байгуулж, тайлант онд 2,516.1 сая төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг хуримтлалын санд хуваарилаад үлдэх хэсгийг нэгдлийн стратеги төлөвлөгөөнд тусгасан ирээдүйд орлого, үнэ цэнийг бий болгох бизнес хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагаанд зарцуулахаар заасан байна. Үүний дагуу тайлант онд нэгдлийн 5 охин компаниас 628,493.0 сая төгрөгийн ногдол ашгийг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрч бүртгэснээс үндэсний баялгийн санд төрд ногдох ашиг 411,687.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус компани нь орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай ажиллаж байгаа хараат болон охин компаниудад зээлийн санхүүжилт олгон, санхүүжилтийн авлага бүрэн барагдаагүй байхад компанийг татан буулгаж байгаа нь зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж, насжилт өндөртэй найдваргүй авлага нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг хоёр удаа шинэчлэн тогтоосон байна. Орон тооны дээд хязгаарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 79 дүгээр тогтоолоор 167 орон тоотой байхаар тогтоосон бол 2025 оны 40 дүгээр тогтоолоор 177, 141 дүгээр тогтоолоор 159 орон тоотой байхаар шинэчлэн баталсан байна.

Тус компани тайлант онд 5 чиглэл, 22 зорилтын хүрээнд нийт 324 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 91.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Дээрх асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



SM

С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	207,865,128,269.98	262,585,784,459.58
1.1.2	Дансны авлага	9,458,692,986.81	15,718,276,472.09
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,188,277,011.15	3,666,925,656.25
1.1.4	Бусад авлага	3,369,516,551,916.23	6,586,544,713,685.55
1.1.6	Бараа материал	43,663,386.99	36,596,418.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	17,322,149,995.58	30,041,138,043.54
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,606,394,463,566.74	6,898,593,434,735.81
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	120,128,524,988.84	124,381,332,149.58
1.2.2	Биет бус хөрөнгө	23,904,826.69	347,758,556.38
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,168,429,855,101.16	9,168,440,855,101.16
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	12,371,245,852.08	14,011,124,432.21
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	984,844,528,263.86	1,269,253,872,568.98
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,285,798,059,032.63	10,576,434,942,808.31
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,892,192,522,599.37	17,475,028,377,544.12
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,166,319,007.18	1,462,011,506.16
2.1.1.2	Цалингийн өглөг	543,689.99	-
2.1.1.3	Татварын өр	23,091,866,106.90	36,164,577,202.26
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,272,297.80	18,943,627.13
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	494,452,182.95	97,002,185,293.82
2.1.1	Богино хугацаат өр төлбөрийн дүн	25,760,453,284.83	134,647,717,629.37
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	867,324,791,384.84	868,830,626,384.84
2.1.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	867,324,791,384.84	868,830,626,384.84
2.2	Өр төлбөрийн нийт дүн	893,085,244,669.67	1,003,478,344,014.21
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) Төрийн	100,000,000.00	100,000,000.00
	в) хувьцаат	5,000,000.00	5,000,000.00

2.3.5	Дахин үнэлгээний нөөц	1,498,619,291.40	1,498,619,291.40
2.3.6	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	9,165,477,942,843.16	9,165,477,942,843.16
2.3.7	Хуримтлагдсан ашиг	3,832,025,715,795.14	7,304,468,471,395.36
2.3	Эзэмшигчдийн өмчийн дүн	12,999,107,277,929.70	16,471,550,033,529.92
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,892,192,522,599.37	17,475,028,377,544.12

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	281,779,646,811.23	295,385,166,646.04
2	Борлуулалтын өртөг	(28,358,239,724.00)	(30,080,888,852.92)
	Нийт ашиг (алдагдал)	253,421,407,087.23	265,304,277,793.12
4	Хүүний орлого	19,649,400,432.91	36,305,136,712.59
5	Ногдол ашгийн орлого	3,305,196,752,456.20	3,264,229,667,808.73
7	Бусад орлого	169,667,892.08	986,600,254.40
9	Ерөнхий ба удирдлагын зардал	(22,298,288,582.10)	(30,911,701,058.91)
10	Санхүүгийн зардал	(1,417,773,018.20)	(892,957.57)
11	Бусад зардал	(2,463,321,848.90)	(1,225,504,155.06)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	256,056,599.70	52,218,653.62
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	(19,395,833.10)	(46,181,818.18)
	Татвар төлөхийн өмнөх ашиг	3,552,494,505,185.82	3,534,693,621,232.74
15	Орлогын татварын зардал	(58,553,984,326.44)	(61,576,365,414.84)
	Татварын дараах ашиг (алдагдал)	3,493,940,520,859.38	3,473,117,255,817.90
16	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
17	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,493,940,520,859.38	3,473,117,255,817.90
18	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Бусад олз гарз	-	-
19	Орлогын нийт дүн	3,493,940,520,859.38	3,473,117,255,817.90
20	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг алдагдал	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	105,000,000.00	-	-	1,498,619,291.40	9,165,477,942,843.16	339,888,846,045.51	9,506,970,408,180.07
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	(1,803,651,109.34)	(1,803,651,109.34)
Залруулсан үлдэгдэл	105,000,000.00	-	-	1,498,619,291.40	9,165,477,942,843.16	338,085,194,936.17	9,505,166,757,070.73
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	3,493,940,520,858.97	3,493,940,520,858.97
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	105,000,000.00	-	-	1,498,619,291.40	9,165,477,942,843.16	3,832,025,715,795.14	12,999,107,277,929.70
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	(674,500,217.68)	(674,500,217.68)
Залруулсан үлдэгдэл	105,000,000.00	-	-	1,498,619,291.40	9,165,477,942,843.16	3,831,351,215,577.46	12,998,432,777,712.02
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	3,473,117,255,817.90	3,473,117,255,817.90
2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	105,000,000.00	-	-	1,498,619,291.40	9,165,477,942,843.16	7,304,468,471,395.36	16,471,550,033,529.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	554,874,189,552.67	349,144,079,438.73
1.1.2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	145,859,071,733.67	132,338,139,703.20
1.1.6	Бусад мөнгөн орлого	409,015,117,819.00	216,805,939,735.53
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	740,126,624,130.02	154,896,138,363.17
1.2.1	Ажиллагчдад олгосон цалин, урамшуулал	8,579,879,399.60	14,815,357,409.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,140,254,873.00	3,819,612,874.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	656,227,313.00	9,626,635,663.10
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	61,300,197.52	168,358,755.76
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	120,307,960.50	96,901,071.40
1.2.6	Төлсөн хүү	1,963,625,312.52	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	142,058,692,153.26	79,532,212,144.22
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	176,314,144.00	12,454,870.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	584,370,022,776.62	46,824,605,575.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(185,252,434,577.35)	194,247,941,075.56
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	363,494,617,119.23	85,112,173,278.90
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	351,112,077,062.89	64,061,084,019.50
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	12,382,540,056.34	21,051,089,259.40
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	44,697,268,129.41	224,618,275,352.08
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,629,012,177.50	2,051,589,561.25
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,100,000.00	445,500,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	1,400,000.00	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	1,000,000.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	41,057,755,951.91	222,120,185,790.83
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	318,797,348,989.82	(139,506,102,073.18)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,831,076.37	1,388,464.19
3.1.5	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	2,831,076.37	1,388,464.19
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	109,235,692,684.01	22,571,276.97
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	109,204,880,584.52	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	24,718,823.12	21,882,296.56
3.2.6	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	6,093,276.37	688,980.41

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(109,232,861,607.64)	(21,182,812.78)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	24,312,052,804.83	54,720,656,189.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	183,553,075,465.15	207,865,128,269.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	207,865,128,269.98	262,585,784,459.58

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйцэтгэл	Хувь	2025 төл/2025 гүйцэтгэл	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	Замын хураамжийн орлого	м.төг	129,980,652.3	119,771,360.2	125,435,306.6	(4,545,345.7)	96.5	5,663,946.4	104.7
	Менежментийн орлого	м.төг	151,603,370.8	242,709,710.8	169,835,580.9	18,232,210.1	112.0	(72,874,129.9)	70.0
	Лицензийн талбай ашиглуулсан орлого	м.төг	195,623.7	146,473.0	114,279.2	(81,344.5)	58.4	(32,193.8)	78.0
	Хүүгийн орлого	м.төг	19,649,400.4	6,213,461.8	36,305,136.7	16,655,736.3	184.8	30,091,674.9	584.3
	Ногдол ашгийн орлого	м.төг	3,305,196,752.5	-	3,264,229,667.8	(40,967,084.7)	98.8	3,264,229,667.8	-
	Үйл ажиллагааны бусад орлого	м.төг	425,724.5	-	986,600.3	560,875.8	231.7	986,600.3	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	м.төг	-	-	52,218.6	52,218.6	-	52,218.6	-
2	Нийт орлого	м.төг	3,607,051,524.2	368,841,005.9	3,596,958,790.1	(10,092,734.1)	99.7	3,228,117,784.2	975.2
3	Нийт зардал	м.төг	54,557,019.0	86,650,713.6	62,265,168.9	7,708,149.9	114.1	(24,385,544.7)	71.9
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	22,298,288.6	49,364,910.5	30,911,701.0	8,613,412.4	138.6	(18,453,209.5)	62.6
4	Татварын өмнөх ашиг	м.төг	3,552,494,505.2	282,190,292.2	3,534,693,621.2	(17,800,884.0)	99.5	3,252,503,329.0	1,252.6
5	Орлогын татварын зардал	м.төг	58,553,984.3	69,508,427.6	61,576,365.4	3,022,381.1	105.1	(7,932,062.2)	88.5
6	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	3,493,940,520.8	212,681,864.6	3,473,117,255.8	(20,823,265.0)	99.4	3,260,435,391.2	1,633.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эрдэнэс Монгол ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Төрийн өмчит хуулийн этгээд үүсгэн байгуулах тухай” 266 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2007 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай” 52 дугаар тогтоолын үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий орд газруудад үйл ажиллагаа эрхэлж буй төрийн өмчит компаниудын төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулсан байна.

Тус компани нь “Нэгдлийн компаниудаа нэгдсэн бодлого, стратегиар манлайлан удирдаж, эрдэс баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлж, өнөө болон ирээдүйд үр өгөөж хүртээх тогтолцоог бий болгох” эрхэм зорилгын хүрээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгдлийн зарчмаар ажиллуулах, нэгдлийн бүрэлдэхүүн компаниудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Эрдэнэс Монгол нэгдлийн бүрэлдэхүүн компани, харьяа хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэлээр нь бүлэглэж, Зэс металлын группэд 5, Түлш, эрчим хүчний группэд 6, аж ахуйн нэгж, дэд бүтэц, логистикийн группэд 5 компани харьяалагдаж, нийт 15 охин компани, хараат 15 компани 1 төслийн нэгж, 3 салбар, төлөөлөгчийн газрын бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

Тус компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан байна. Тайлант онд 5 чиглэл, 22 зорилтын хүрээнд нийт 324 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 91.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Засгийн газрын 2023 оны 108 дугаар тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулахаар тусгасан байна. Үүнд:

- Компани нь өөрийн болон компанийн охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгжийн эрдэс баялгийн хайгуул, олборлолт, боловсруулалт, борлуулалт, тээвэр логистик, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдлага, менежментээр хангах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;
- Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ;
- Компани нь хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг явуулах эрхтэй;

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэсэн статустай байна. Тус компани нь Засгийн газрын эзэмшлийн нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100,000,000.00 /нэг зуун сая/ ширхэг энгийн, Монгол Улсын иргэдийн эзэмших нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000,000.00 /таван сая/ ширхэг давуу эрхийн зарласан хувьцаатай бөгөөд компани хувьцаат компани болох тохиолдолд хэрэгжихээр заасан байна.

Тайлант онд Эрдэнэс Монгол ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ыг шинэчлэн баталж орон тооны дээд хязгаарыг 167 байхаар тогтоож, гүйцэтгэх захирлын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/158 дугаар тушаалаар

“Компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, орон тооны хязгаар, албан тушаалын жагсаалт”-ыг баталсан;

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ыг шинэчлэн баталж орон тооны дээд хязгаарыг 177 байхаар тогтоож, гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/48 дугаар тушаалаар “Компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, орон тооны хязгаар, албан тушаалын жагсаалт”-ыг баталсан;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ыг шинэчлэн баталж орон тооны дээд хязгаарыг 159 байхаар тогтоож, гүйцэтгэх захирлын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/07 дугаар тушаалаар “Компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, орон тооны хязгаар, албан тушаалын жагсаалт”-ыг баталсан;

Тайлант оны гүйцэтгэлээр тус компани гүйцэтгэх захирал, 5 газар, 15 хэлтэс, 1 алба, 3 групп, 6 зөвлөл, 3 салбар төлөөлөгчийн газрын нийт 170 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна. Мөн ТУЗ нь зөвлөлийн 11 гишүүн, дотоод аудитын 20, ажлын албаны 5 нийт 36 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрдэнэс Монгол ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, компанийн удирдлагаас баталсан дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- Ашигт малтмалын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах шаардлагатай асуудлууд байна гэж үзсэн. Тухайлбал компанийн санхүүгийн эрсдэлийг оновчтой тодорхойлоогүй, гол эрсдэл бүхий асуудлуудад хяналт шалгалт хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/119 дүгээр тушаалаар баталсан “Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд мөрдөхөөр боловсруулж, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 76 дугаар тогтоолоор баталсан байна.

Эрдэнэс Монгол ХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдлийн хэмжээнд мөрдөхөөр боловсруулсан бөгөөд тус баримт бичигт компанийн үйл ажиллагаатай холбоотой зарим ажил гүйлгээг хэрхэн бүртгэх, тайлагнах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна. Тухайлбал:

- Зам ашигласны хураамжийн орлого бүрдүүлэх, түүнтэй холбогдон гарах өртөг, зардлыг бүртгэх, тайлагнах талаар;
- Охин болон хараат компаниудаас авч буй менежментийн үйлчилгээний төлбөрийн орлогыг бүртгэх, тайлагнах талаар;
- Охин болон хараат компаниудад олгож буй зээлийн санхүүжилтийн бүртгэл, хөтлөлт, тайлагналын талаар;
- Төлөөлөгчийн газруудад олгож буй санхүүжилт, түүний зарцуулалт, зардлын гүйцэтгэл болон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бүртгэх, тайлагнах талаар;

Дээрх ажил гүйлгээг бүртгэх, тайлагнахад нэгдсэн аргачлалгүйгээс нягтлан бодох бүртгэл, тайлагнал алдаатай илэрхийлэгдэх болон дотоод хяналт алдагдах эрсдэл үүсэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэс Монгол ХХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн боловч тодруулгыг “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,582,835.8 сая төгрөгөөр буюу 25.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	207,865,128.2	262,585,784.5	54,720,656.3
Дансны авлага	9,458,693.0	15,718,276.5	6,259,583.5
Татвар, НДШ-ийн авлага	2,188,277.0	3,666,925.6	1,478,648.7
Бусад авлага	3,369,516,551.9	6,586,544,713.7	3,217,028,161.8
Бараа материал	43,663.4	36,596.4	(7,067.0)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	17,322,150.0	30,041,138.0	12,718,988.0
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,606,394,463.5	6,898,593,434.7	3,292,198,971.3
Үндсэн хөрөнгө	120,128,525.0	124,381,332.1	4,252,807.1
Биет бус хөрөнгө	23,904.8	347,758.6	323,853.7

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,168,429,855.1	9,168,440,855.1	11,000.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	12,371,245.8	14,011,124.4	1,639,878.6
Бусад эргэлтийн бус хөрөнгө	984,844,528.3	1,269,253,872.6	284,409,344.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,285,798,059.0	10,576,434,942.8	290,636,883.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,892,192,522.5	17,475,028,377.5	3,582,835,855.0
Дансны өглөг	2,166,319.0	1,462,011.5	(704,307.5)
Цалингийн өглөг	543.7	-	(543.7)
Татварын өр	23,091,866.1	36,164,577.2	13,072,711.1
Урьдчилж орсон орлого	7,272.3	18,943.6	11,671.3
Бусад богино хугацаат өр төлбөр	494,452.2	97,002,185.3	96,507,733.1
Богино хугацаат өр төлбөрийн дүн	25,760,453.3	134,647,717.6	108,887,264.3
Бусад урт хугацаат өглөг	867,324,791.4	868,830,626.4	1,505,835.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	867,324,791.4	868,830,626.4	1,505,835.0
Өр төлбөрийн нийт дүн	893,085,244.7	1,003,478,344.0	110,393,099.3
Өмч: а) Төрийн	100,000.0	100,000.0	-
в) хувьцаат	5,000.0	5,000.0	-
Дахин үнэлгээний нөөц	1,498,619.3	1,498,619.3	-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	9,165,477,942.8	9,165,477,942.8	-
Хуримтлагдсан ашиг	3,832,025,715.7	7,304,468,471.4	3,472,442,755.7
Эзэмшигчдийн өмчийн дүн	12,999,107,277.8	16,471,550,033.5	3,472,442,755.7
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,892,192,522.5	17,475,028,377.5	3,582,835,855.0

Нийт хөрөнгөнд эргэлтийн хөрөнгө 39.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө 60.5 хувийг эзэлж байна.

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөр дансанд нөлөө бүхий өөрчлөлтүүд орсон байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө данс

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 262,585.8 сая төгрөг болж, өмнөх оноос 54,720.7 сая төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах данс 92,553.3 сая төгрөгийн, гадаад валютын 9.1 мянган ам.доллар буюу 32.5 сая төгрөгийн, банкин дахь богино хугацаат хадгаламж 170,000.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд мөнгөн хөрөнгийн данстай холбоотой дараах томоохон ажил гүйлгээ гарсан байна. Тухайлбал:

- Менежментийн үйлчилгээний төлбөрт Эрдэнэс Тавантолгой ХК-аас 30,000.0 сая төгрөг, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-аас 20,000.0 сая төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨҮГ-аас 5,835.2 сая төгрөг, нийт 55,835.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн;
- Нэгдлийн 5 охин компаниас 628,493.0 сая төгрөгийн ногдол ашгийн орлого бүрдүүлсэн;
- Замын хураамжийн төлбөр 132,162.5 сая төгрөгийн орлогыг 310 компаниас бүрдүүлсэн;
- Үндэсний баялгийн санд 2024 оны ногдол ашгаас 411,687.6 сая төгрөгийг шилжүүлсэн;
- Нэгдлийн охин болон хараат 6 компанид 18,666.1 сая төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон;

3.4.2 Авлага данс

Авлагын дансны үлдэгдэл 6,605,929.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3,224,766.4 сая төгрөгөөр буюу 95.4 хувиар өссөн нь борлуулалтын авлага, холбоотой талаас авах авлага нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Борлуулалтын авлага өмнөх оноос 66.2 хувиар буюу 6,259.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 15,718.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 370 гэрээт компаниас авах 15,701.5 сая төгрөгийн замын хураамжийн орлогын авлага байна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага дансны үлдэгдэл 3,666.9 сая төгрөг болж өмнөх оноос 1,478.6 сая төгрөгөөр буюу 67.6 хувиар өссөн нь Гашуун сухайт авто замын 2024-2025 оны зам засварын ажил гүйцэтгэсэн компаниудын НӨАТ-ыг НӨАТ-ын хойшлогдсон авлага дансанд бүртгэж хувь тэнцүүлэн падаан үүсгэж сар бүр тэнцүү дүнгээр хорогдуулан, авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалсан байна.

Холбоотой талаас авах авлагын үлдэгдэл 130,842.7 сая төгрөг болсон нь менежментийн үйлчилгээний төлбөртэй холбоотой Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 75,776.3 сая төгрөгийн, Эрдэнэс Тавантолгой ХК-аас 20,953.6 сая төгрөгийн, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-аас 16,501.3 сая төгрөгийн, Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-аас 11,241.7 сая төгрөгийн, Эрдэнэс Алт Ресурс ХХК-аас 6,344.4 сая төгрөгийн авлагууд байна.

Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох Эрдэнэс Тавантолгой ХК-аас авах ногдол ашгийн авлагын үлдэгдэл 6,448,048.2 сая төгрөг болж, өмнөх оноос 95.1 хувиар буюу 3,142,851.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2019 оны ногдол ашгаас 762,988.7 сая төгрөгийн, ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 тогтоолоор тус компанийн 2024 оны цэвэр ашгаас 2,379,862.7 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилснаас шалтгаалсан байна. Хүүний авлагын үлдэгдэл 6,984.6 сая төгрөг болж, нэмэгдсэн нь Төрийн банкин дахь 1,761.1 сая төгрөгийн, Хас банкин дахь 171.0 сая төгрөгийн, Голомт банкин дахь 3,400.5 сая төгрөгийн, Хаан банкин дахь 1,652.1 сая төгрөгийн хадгаламжийн хүүний хуримтлагдсан авлагууд байна.

Найдваргүй авлагын нөөц

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 45 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт найдваргүй авлагын нөөцийг 1 жилийн дотор бол байгуулахгүй, 1-2 хүртэл жилийн насжилттай бол 10.0 хувиар, 2-3 хүртэл жил бол 20.0 хувиар, 3-аас дээш жил бол 100.0 хувиар байгуулахаар тус тус заасан байна.

Тайлант оны дансны авлагыг тооцохдоо насжилтыг харгалзан найдваргүй авлагын нөөцийг хасаж, цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Хүснэгт 2. Авлагын насжилт, найдваргүй авлагын нөөцийн тооцоо

/мянган төгрөгөөр/

Авлагын насжилт	Авлагын дансны дүн	Нөөц байгуулах хувь	Найдваргүй авлагын нөөцийн дүн	Авлагын цэвэр дүн	Хувийн жин
1 хүртэл жилийн насжилттай	15,698,246.3	0.0	-	15,698,246.3	99.9
1-2 хүртэл жилийн насжилттай	15,033.9	10.0	(1,503.4)	13,530.5	0.1
2-3 хүртэл жилийн насжилттай	8,124.5	20.0	(1,624.9)	6,499.6	-
3-аас дээш жилийн насжилттай	358,566.0	100.0	(358,566.0)	-	-
Нийт дүн	16,079,970.7	-	(361,694.3)	15,718,276.4	100.0

Эх сурвалж: Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 45 дугаар тогтоолоор баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Дансны авлагын 15,698.2 сая төгрөг буюу 99.9 хувь нь 1 хүртэл жилийн насжилттай, 20.0 сая төгрөг буюу 0.1 хувь нь 1-3 жилийн насжилттай байна.

Тайлант оны найдваргүй авлагын нөөц нь дансны авлагын 2.3 хувийг эзэлж байна.

Авлагын шинжилгээ

Тайлант оны дансны авлага 66.2 хувиар, борлуулалтын орлого 2.6 хувиар тус тус өссөн байна. Дансны авлагын өсөлт борлуулалтын орлогын өсөлтөөс 25.5 дахин өндөр үзүүлэлттэй байгаа нь менежментийн үйлчилгээний төлбөрийн орлогын 57.3 хувь нь мөнгөөр төлөгдөөгүй, авлага цуглуулах чадвар хангалтгүйгээс шалтгаалсан байна.

Дансны авлага цуглуулах дундаж хоног өмнөх оноос 1.4 хоногоор удааширч 15.6 хоног, авлагын борлуулалтад эзлэх хувь өмнөх оноос 5.2 хувиар өсөж 12.5 хувь болж авлагын хэмжээ нэмэгдсэн байна. Энэ нь компанийн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж байгаа тул цаашид авлагын удирдлагыг сайжруулах шаардлагатай байна.

3.4.3 Урьдчилгаа данс

Урьдчилгаа дансны үлдэгдэл 30,041.1 сая төгрөг болж, өмнөх оноос 12,719.0 сая төгрөгөөр буюу 73.4 хувиар өссөн байна. Тухайлбал:

Урьдчилж төлсөн тооцоо:

- Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /Jorc/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө, нэмэлт хайгуулын ажил, хагас үйлдвэрлэлийн технологийн дээжлэлт, туршилт хийж үр дүнгийн тайлан боловсруулж, батлуулах ажилтай холбоотой 16,315.3 сая төгрөгөөр;
- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Шинэ Хархорум" хотын төлөвлөлтөд тусгагдсан ногоон байгууламж, ойн зурвас байгуулах зорилтыг хангаж 21.0 мянган ширхэг навчит, 9.0 мянган ширхэг шилмүүст мод тарихтай холбоотой 2,120.3 сая төгрөгөөр;

Урьдчилж гарсан зардал:

- Гашуун сухайт автозамын засварын ажилд 5,671.0 сая төгрөгөөр, Эрдэнэс ҮТП ХХК-ийн шохойн үйлдвэрийн төсөлтэй холбоотой 4,957.0 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.4.4 Бараа материал данс

Бараа материал дансны үлдэгдэл 36.6 сая төгрөг болж өмнөх оноос 7.1 сая төгрөгөөр буюу 16.2 хувиар буурсан байна.

Тайлант онд 677.8 сая төгрөгийн бичиг хэрэг, хангамжийн материал, түлш шатахуун зэргийг худалдан авч, 684.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө данс

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 124,381.3 сая төгрөг болж өмнөх оноос 4,252.8 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн байна. Тухайлбал:

- Компанийн үйл ажиллагаанд ашиглахаар 21,212.3 сая төгрөгийн 324 нэр төрлийн хөрөнгийг худалдан авсан;
- ТӨБЗГ-ын 2025 оны 823 дугаар тогтоолоор бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 508.0 сая төгрөгийн хөрөнгийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-д балансаас баланст шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 840 дүгээр тогтоолоор 435.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан;

- Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар "Vnware vSphere 7 Enterprise Plus" нэртэй 80.2 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 111.1 сая төгрөгийн барилгыг ангилал хооронд залруулсан;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугаман аргаар тооцдог бөгөөд 16,451.5 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулсан;

Дуусаагүй барилга байгууламжийн дансанд нийт 3,693.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах барилга байгууламж бүртгэлтэй байна. Тухайлбал:

- Гашуун сухайт автозамын ажилчдын амрах байр-2,949.3 сая төгрөг;
- Шалган нэвтрүүлэх цэг-3 барилгын ажил- 389.7 сая төгрөг;
- Шалган нэвтрүүлэх цэг-1 барилгын ажил-354.3 сая төгрөг;

3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт данс

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 9,168,440.8 сая төгрөг болж, өмнөх оноос 11.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 223 тогтоол, Эрдэнэс монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 15 дугаар тогтоолоор Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийг байгуулж 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн;
- Монгол улсын Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 154 дүгээр тогтоолоор Зэс боловсруулах цогцолбор ХХК-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулж, 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн;

3.4.7 Бусад эргэлтийн бус хөрөнгө данс

Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэл 1,269,253.9 сая төгрөг болж, өмнөх оноос 28.9 хувиар буюу 284,409.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн тогтоолоор Багануур ХК, Шивээ-Овоо ХК-ийн хугацаа хэтэрсэн гадаад зээллэг болон дамжуулан зээлийн өрийг төлж барагдуулах үүрэг болгосны дагуу зээлийн санхүүжилт олгосон бөгөөд тайлант онд 270,209.9 сая төгрөгийн санхүүжилтийн, 13,686.2 сая төгрөгийн хуримтлагдсан хүүний нийт 283,896.1 сая төгрөгийн авлагыг урт хугацаат авлагаар бүртгэсэн;
- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх шийдвэрийн дагуу "Эрдэнэс бонд-1,2,3" нэртэй бонд гаргасан бөгөөд үүнээс "Эрдэнэс бонд-1" бондыг 2024 оны 12 дугаар сарын 30 өдрөөр төлж барагдуулахаар Хөгжлийн банктай гэрээ байгуулсан байна. Тус бондын төлбөрийг "Эрдэнэс Алт ресурс" ХХК хариуцан төлөх бөгөөд төлбөрийн үлдэгдэл 849,973.0 сая төгрөгийн урт хугацаат авлага;
- Бусад урт хугацаат авлага дансанд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-д Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 177 дугаар тогтоолоор 335,789.02 ам.доллар буюу 1,194.3 сая төгрөгийн хүүгүй зээлийг олгосон боловч одоог хүртэл төлөгдөөгүйгээс үүссэн авлага;
- Барьцааны авлага дансанд Солонгос дахь төлөөлөгчийн газрын оффис, ажилчдын орон сууц болон автомашины түрээсийн барьцаанаас үүссэн 467.5 сая төгрөгийн авлага тус тус бүртгэгдсэн.

3.4.8 Өр төлбөр данс

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,003,478.3 сая төгрөг болж, өмнөх оноос 110,393.1 сая төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна. Тухайлбал:

Богино хугацаат өр төлбөр:

- Тайлант онд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 03 тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашигт 95,427.2 сая төгрөгийг ногдуулан хуваарилж, өглөг үүсгэсэн;
- Татварын өр төлбөр дансны үлдэгдэл 13,072.7 сая төгрөг буюу 56.6 хувиар өссөн нь ААНОАТ-н өр 7,963.7 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан;

Урт хугацаат өр төлбөр:

- Урт хугацаат өр төлбөрийн 97.8 хувь нь "Эрдэнэс бонд 1" бондтой холбоотой 849,973.0 сая төгрөгийн өглөг;
- Урт хугацаат өр төлбөрийн 2.2 хувь нь Шивээ-Овоо ХК-ийн Эрдэнэс Тавантолгой ХК-аас авсан дамжуулан зээл, хүүгийн 18,857.0 сая төгрөгийн өглөг байна;

3.4.9 Эздийн өмч данс

Эздийн өмч данс 16,471,550.0 сая төгрөг болж өмнөх оноос 3,472,442.8 сая төгрөгөөр буюу 26.7 хувиар өссөн нь тайлант үеийн цэвэр ашгийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Тус дансанд эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг 55.6 хувь буюу 9,165,477.9 сая төгрөг, хуримтлагдсан ашиг 44.3 хувь буюу 3,832,025.7 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 0.1 хувь буюу 1,498.6 сая төгрөгийг эзэлж байна.

Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг:

- Эрдэнэс монгол ХХК-ийн охин компаниудад оруулсан 9,165,477.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дүн байна.

Хуримтлагдсан ашиг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга:

- Хуримтлагдсан ашиг данс 7,304,468.5 сая төгрөг болж, өмнөх оноос 3,472,442.7 сая төгрөгөөр буюу 90.6 хувиар өссөн нь тайлант үеийн цэвэр ашиг 3,473,117.2 сая төгрөгөөр өсөж, нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн алдааны залруулга 674.5 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3¹-т заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор 2025 оны төсөв болон ТУЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, санхүүжилтийн хэмжээг тус тус баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 368,841.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 86,650.7 сая төгрөгөөр, төсвийн төлбөрт 96,608.2 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 212,681.9 сая төгрөг байхаар, хөрөнгө оруулалтаар өмнөх оноос дамжин болон шинээр хэрэгжүүлэх нийт


¹ 20.1.Захирал дараахь эрх, үүрэгтэй:3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

8,713,322.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээнд 114,906.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

Орлого үр дүнгийн төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд 295,385.2 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 3,473,117.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашиг борлуулалтын орлогоос 11.7 дахин өссөн байна.

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БА ЦЭВЭР АШГИЙН ХАРЬЦАА /САЯ.ТӨГ/



Гүйцэтгэлээр 3,596,958.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 62,265.2 сая төгрөгийн зардал гарган, орлогын албан татварт 55,110.4 сая төгрөг төвлөрүүлж, 3,473,117.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Эх сурвалж: 2025 оны санхүүгийн тайлан



Нийт орлогын 90.8 буюу 3,264,229.7 сая төгрөгийг ногдол ашгийн орлого, 4.7 хувь буюу 169,835.6 сая төгрөгийг менежментийн орлого, 3.5 хувь буюу 125,435.3 сая төгрөгийг замын хураамжийн орлого, 1.0 хувь буюу 36,305.1 сая төгрөгийг хүүгийн орлого тус тус бүрдүүлж байна.

Эх сурвалж: 2025 оны санхүүгийн тайлан

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 24,385.5 сая төгрөгөөр буюу 28.1 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Тухайлбал:

- Ерөнхий удирдлагын зардал төлөвлөснөөс 37.0 хувь буюу 18,286.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь төлөөлөгчийн газрын зардал 70.0 хувь буюу 3,096.4 сая төгрөг, цалингийн зардал 14.0 хувь буюу 2,599.4 сая төгрөг, төлөөлөн удирдах зөвлөл 44.0 хувь буюу 2,684.7 сая төгрөг, мэргэжлийн үйлчилгээний зардал 47.0 хувь буюу 2,077.7 сая төгрөг, гэрээт ажил 58.0 хувь буюу 2,139.6 сая төгрөг зэрэг дутуу зарцуулсан;
- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг төлөвлөснөөс 11.0 хувь буюу 1,450.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн.

Нийт зардлын 46.6 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 48.2 хувийг ерөнхий удирдлагын, 5.2 хувийг бусад зардал эзэлж байна.

Хөрөнгө оруулалт

Тайлант онд Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталж, 115,156.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 129 нэр төрлийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин тайланд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг толилуулж ирүүлээгүй байна.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн Б/260 дугаар тушаалаар “Компанийн нийт ажилтнуудад ажлын өдөр олгох хоол, унааны нөхөн олговрын хэмжээг 13.0 мянган төгрөг” байхаар баталсан байна. Өмнөх оны гүйцэтгэлээр хоол, унааны зардалд 333.9 сая төгрөгийг зарцуулсан бол тайлант онд тус зардалд 650.2 сая төгрөгийн төсөв баталж, 489.6 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 46.6 хувиар өссөн байна.
- БНХАУ, ОХУ, БНСУ, Австрали, Канад, Индонез, БНЭУ, БНФУ, АНУ, Оман улсуудад зохион байгуулагдсан Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн стратегийн зөвлөгөөн, PDAC арга хэмжээ, “Mongolia–Korea Critical Minerals–Mining Investment” уулзалт, гангийн үйлдвэрүүд болон хуурай боомт, логистикийн төвүүдийн үйл ажиллагаатай танилцах айлчлал, мөн нүүрсний уурхайн бүтээн байгуулалт, хөгжүүлэлтийн форумд оролцохтой холбоотойгоор тайлант онд гадаад томилолтын зардалд 793.1 сая төгрөгийн төсөв баталснаас 619.0 сая төгрөгийг зарцуулж, гадаад томилолтын зардал өмнөх оноос 53.4 хувиар өссөн байна.
- Өмнөх онд компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлахтай холбоотой ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн 4 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 111.1 төгрөгийг компаниас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, тайлант онд нэмж 8 ажилтанд 350.9 сая төгрөгийг компаниас төлсөн, тус зардлын хэмжээ өмнөх оноос 2.1 дахин өссөн байна.
- Тайлант онд “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ыг орон тооны дээд хязгаарыг хоёр удаа шинэчлэн баталсан байна. Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор бүтэц, орон тооны дээд хязгаарыг 177 байхаар шинэчлэн баталснаас, гүйцэтгэлээр 170 орон тоотой ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор 159 байхаар тогтоож, Гүйцэтгэх захирлын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/07 дугаар тушаалаар “Компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, орон тооны хязгаар, албан тушаалын жагсаалт”-ыг баталсан байна.
- Тайлант онд мэдээ мэдээлэл бэлтгэх, түгээх, хүргэхэд хамтрах ажиллах зорилгын хүрээнд 41 хэвлэл, мэдээллийн байгууллагатай 424.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 484.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх ажлын даалгаврыг боловсруулахдаа төсвийн

тооцоолол хийлгүйгээр ерөнхий байдлаар боловсруулж гэрээний үнийг 4.9-19.8 сая төгрөгийн дүнтэйгээр нийтлэг байдлаар байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/30 дугаар тушаалаар “Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан нь ТБОНӨХБАҮХАТХ болон холбогдох журамд заасан цагалбарт хугацаатай нийцэхгүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тайлант онд 52,998.4 сая төгрөгийн төсвөөр 307 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 28,407.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 137 бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна.

Худалдан авах ажиллагааны тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Эрдэнэс Монгол ХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитор Б.Батхишиг нар гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс Монгол ХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/219 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 113,111.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,131.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн бөгөөд орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай ажиллаж байгаа хараат болон охин компаниудад зээлийн санхүүжилт олгож насжилт өндөртэй найдваргүй авлага үүсгэн авлагыг барагдуулаагүй байхад татан буулгасан, менежментийн үйлчилгээг нэгдсэн байдлаар жигд, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлээгүй, охин, хараат компаниудад эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийгээгүй, дотоод хяналт сул байгаа зэрэг асуудлуудад шинж чанарын хувьд материаллаг байдал тооцов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй, тусгайлсан арга хэмжээ авч ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 2,635.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус компанийн батлагдсан төсөв, тухайн жилийн зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлбар, хагас жилийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайлант хугацаанд 5 сая төгрөгөөс дээш гэрээний дүн бүхий нийт 918.7 сая төгрөгийн худалдан авалтын мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.6 “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4.1.1 “худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар”, 4.1.2 “төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар”, 4.1.8 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Тус компанийн хараат болон охин компаниуд нь төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилготой ч дийлэнх нь алдагдалтай, үр ашиггүй ажиллаж, шинээр охин компаниуд нэмж байгуулах зэргээр төрийн өмчийн үр ашгийг бууруулж байна. Мөн тус компани нь эдийн засгийн үр ашиг нь хэзээ гарах нь тодорхойгүй, байгуулагдсан цагаасаа алдагдалтай ажиллаж байгаа компаниудад үр ашгийн шинжилгээ хийгээгүй, алдагдалтай ажилласан шалтгаан нөхцөлийг тодорхойлоогүй, алдагдлыг бууруулах, компаниудыг нэгтгэх, татан буулгах зэрэг арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн

дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21^{1.11} “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах саналыг Засгийн газарт хүргүүлнэ”-ийн 1 “энэ хуулийн 21¹ дүгээр зүйлийн 3¹-д заасны дагуу эцэслэн тохирсон зорилтын саналын хэрэгжилт гурван жил дараалан хангалтгүй гэж дүгнэгдсэн”, 2 “үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд гурван жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анх байгуулагдсанаас хойш алдагдалтай ажиллаж байгаа хараат болон охин компаниудад үр ашгийн шинжилгээ хийгээгүй, алдагдалтай ажилласан шалтгаан нөхцөлийг тодорхойлоогүй, алдагдлыг бууруулах, компаниудыг нэгтгэх, татан буулгах зэрэг арга хэмжээ авдаггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-2: Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор компанийн 2025 оны төсвийг баталсан бөгөөд "Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг" холбогдох хууль болон журамд заасан цаглабарт хугацаанаас хоцроож, гүйцэтгэх захирлын 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3 "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1 "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна", 2.6 "Захиалагч төрийн байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага төлөвлөгөөг батлагдсан төсөв болон хуульд нийцсэн эсэхийг хянан баталж, санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох дээд шатны байгууллагад төлөвлөгөөг цахим системээр илгээнэ", 2.8 "Энэ журмын 1.7-д заасан захиалагчийн гүйцэтгэх удирдлага төлөвлөгөөг батлагдсан төсөв болон хуульд нийцсэн эсэхийг хянан, батална. Захиалагчийн баталгаажуулсан төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор цахим системд нийтэлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахдаа хуульд заасан цаглабарт хугацааг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-3: Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 98.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сургалтуудыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна. Мөн сургалтыг төлөвлөхдөө байгууллагын хэрэгцээ, шаардлагыг эрэмбэлж үнэлээгүй, хэрэгжүүлсэн сургалтын үр дүн, өгөөжийг тооцоогүй, төлөвлөгөөнд тусгаагүй 54.5 сая төгрөгийн 6 сургалтыг тайлант хугацаанд зохион байгуулж, ижил төрлийн сургалтуудын төсвийг хуваан шууд худалдан авалтын аргаар гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш

боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 10 дугаар зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд сургалтын хэрэгцээ, шаардлагыг эрэмбэлэн үнэлээгүй, компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй сургалтуудыг шууд гэрээ байгуулан худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-4: Тайлант онд 876.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэн батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх, тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 10 дугаар зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-5: Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 44 төсөл арга хэмжээнд гэрээний нийт дүнгээр 560.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Мөн тайлант онд он дамжин хэрэгжиж буй зарим төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна”, 3 “Тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-6: Тайлант онд 280.0 сая төгрөгөөр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах төсөл, арга хэмжээний төлөвлөгөө баталсан боловч төлөвлөгөөнд туссан төсөвт өртгөөс хэтрүүлж тайлант онд 41 хэвлэл, мэдээллийн байгууллагатай 424.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 484.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх ажлын даалгаврыг боловсруулахдаа төсвийн тооцоолол хийлгүйгээр ерөнхий байдлаар боловсруулж гэрээний үнийг 4.9-19.8 сая төгрөгийн дүнтэйгээр нийтлэг байдлаар байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 10 дугаар зүйлийн удирдлагын даргын албан тушаалд 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.1 “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх ажлын даалгаврыг боловсруулахдаа төсвийн тооцоолол хийлгүйгээр ерөнхий байдлаар боловсруулж гэрээний үнийн дүнг нийтлэг байдлаар тогтоосон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан нийт төсөвт өртгийн дүнгээс илүү дүнгээр гэрээ байгуулж, гүйцэтгэл гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-7: Тайлант онд шууд худалдан авалтын аргаар худалдан авсан зарим бараа, ажил, үйлчилгээ нь ажлын даалгаваргүй, техникийн тодорхойлолтгүй, хүлээн авсан комиссын болон гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Мөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг нарийвчлан боловсруулахгүйгээр ерөнхий байдлаар боловсруулдаг, зарим гэрээнд гэрээний үнийн дүнг тодорхой тусгадаггүй, гэрээ дүгнэсэн актад гэрээнд заасан шалгуурууд болон актаар хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээний хугацаа, нэр төрлийн талаар нарийвчлан тодорхой тусгалгүйгээр дүгнэдэг зэрэг нь талуудын гэрээний хариуцлага алдагдах, төлөвлөсөн төсвийг хэтрүүлэн зарцуулах, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгааг илтгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 12.2 “Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг

тодорхойлно” 39 дүгээр зүйлийн 39.3.1 "гэрээний үнэ", Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 "Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ", 344 дүгээр зүйлийн 344.1 "Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно", 344.2 "Ажил гүйцэтгэсний хөлсийг талууд тохиролцоогүй боловч гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал зэргээс шалтгаалан захиалагч тухайн төрлийн ажил гүйцэтгэхэд мөрддөг эрх бүхий байгууллагаас баталсан жишиг үнэлгээний жагсаалт байвал тухайн жагсаалтыг үндэслэн, тийм жагсаалт байхгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлс төлнө" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим төсөл, арга хэмжээг ерөнхий байдлаар боловсруулсан, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2.2 Зөвлөмж

1. Бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК нь нэгдлийн урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулаагүй, зөвхөн Засгийн газрын баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон 2024-2028 оны нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд үндэслэж байгаа нь ирээдүйд урт хугацаанд хэрэгжих стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх болон улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд үе шаттай, өгөөжтэй оруулах бодлого, чиглэлийг тогтвортой, иж бүрэн байдлаар тодорхойлох зорилго хангагдахгүй байх нөхцөл үүссэн байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тогтоолоор батлагдсан ЭМГЛ ХХК-ийн дүрмийн 3.2.7.1 “нэгдлийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрдэнэс Монгол ХХК нь компанийн дүрэмд заасан нэгдлийн урт хугацааны стратеги төлөвлөгөөг улсын хөгжлийн бодлого, салбарын чиг хандлагатай уялдуулан боловсруулахад анхаарч ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдлийн хэмжээнд мөрдөхөөр боловсруулсан боловч тус баримт бичигт компанийн үйл ажиллагаатай холбоотой зарим ажил гүйлгээг хэрхэн бүртгэх, тайлагнах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна. Тухайлбал:

- Зам ашигласны хураамжийн орлого бүрдүүлэх, түүнтэй холбогдон гарах өртөг, зардлыг бүртгэх, тайлагнах талаар тодорхой тусгагдаагүй;
- Охин болон хараат компаниудаас авч буй менежментийн төлбөрийн орлогыг бүртгэх, тайлагнах талаар зохицуулалт тусгагдаагүй;
- Охин болон хараат компаниудад олгож буй зээлийн санхүүжилтийн бүртгэл, хөтлөлт, тайлагналын зохицуулалт тодорхойгүй;
- Төлөөлөгчийн газруудад олгож буй санхүүжилт, түүний зарцуулалт, зардлын гүйцэтгэл болон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бүртгэх, тайлагнах талаар зохицуулалт тусгагдаагүй байна.

Дээрх ажил гүйлгээг бүртгэх, тайлагнахад нэгдсэн аргачлалгүйгээс нягтлан бодох бүртгэл, тайлагнал алдаатай илэрхийлэгдэх болон дотоод хяналт алдагдах эрсдэл үүсэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажил гүйлгээг бүртгэх, тайлагнахтай холбоотой зохицуулалтыг компанийн үйл ажиллагааны онцлог, стандартад нийцүүлэн нэмж тусгах.

3. Ахмадын сан байгуулахтай холбоотой асуудал

МУЗГ-ын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэмд ахмадын сан байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох талаар тусгаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 "Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана"-ийн 16.2.8 "Ахмадын сан байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох", Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", МУЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолоор батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" -ын 1.2."Байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан мөнгөн хөрөнгөөр ахмадын сан байгуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн дүрэмд "Ахмадын сан" байгуулах, сангийн эх үүсвэр, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох, бүрдүүлэлт, зарцуулалт, хяналтын зохицуулалтыг тодорхой тусгах.

4. Авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал

Компанийн өмчлөлд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр бүхий улсын дугаар ашиглаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн өмчлөлд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүдэд холбогдох хууль, журамд заасан шаардлагын дагуу бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр бүхий улсын дугаар авах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд дээрх шалгасан зүйлсийн нөлөөллийг эс тооцвол холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулан, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үнэлж, залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгуулахаар аудитын тайланд тусгасан.

Завсрын аудитаар нийт 103,728.2 сая төгрөгийн 49 алдаа, зөрчил илэрсэнд 75,259.2 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 677.5 сая төгрөгийн 11 зөвлөмжийг хэрэгжүүлсэн, бусад алдаа, зөрчлийн тухайд нотлох баримтыг үндэслэн дахин үнэлж, жилийн эцсийн аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 177,238.7 сая төгрөгийн 11 зөрчлөөс 10.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 176,936.0 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 291.8 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг тус тус өгсөн байна. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	10,950.0	1	10,950.0	100.0
Зөвлөмж	3	291,800.8	3	291,800.8	100.0
Албан шаардлага	7	176,935,989.7	3	181,647.5	0.1
Нийт дүн	<u>11</u>	<u>177,238,740.54</u>	<u>7</u>	<u>484,398.3</u>	<u>66.7</u>

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, таслан зогсоох, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн боловч дараах шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай, үр ашиггүй үйл ажиллагаа явуулж буй хараат болон охин компаниудад зээлийн санхүүжилт олгосоор байгаа нь эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж, насжилт өндөртэй найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бүрдүүлж, тайлант онд дахин зээлийн санхүүжилт олгосон байна.
- Компанийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах, компанийн үйл ажиллагаанд ашигладаггүй хөрөнгүүдийг эрх бүхий байгууллагаар холбогдох тушаал шийдвэрийг гаргуулаагүй, санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй байна;
- Ажлаас чөлөөлөгдсөн өмнөх гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй холбоотой авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.
- Шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олговрыг компаниас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Хэрэгжилт хангалтгүй албан шаардлагыг дахин үнэлж дараагийн шатны арга хэмжээг авахаар аудитын тайланд тусгалаа.

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэн, нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлж, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудад хандах нь зүйтэй байна. Үүнд:

1. Охин болон хараат компанитай холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 15 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлээр Салхитын мөнгөний ордыг түшиглэн Эрдэнэс силвер ресурс ХХК-ийг байгуулсан бөгөөд 2020 онд тэтгэврийн зээлийн төлбөрийг барагдуулах зорилгоор Монгол банкаар дамжуулан 1,145,467.7 сая төгрөгийн /Эрдэнэс-1 бонд 929,973.0 сая төгрөг, Эрдэнэс-2 бонд 194,085.7 сая төгрөг, Эрдэнэс-3 бонд 21,409.5 сая төгрөг/ бондыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төлж дуусгах хугацаатай гаргасан байна. Гэвч 2025 оны байдлаар хугацаандаа төлөгдөөгүй 849,973.0 сая төгрөгийн бондын өглөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд Эрдэнэс алт ресурс ХХК-ийн Салхитын мөнгөний ордын нөөц дуусаж байгаагаас үүдэн цаашид бондын үндсэн төлбөр болон хугацаа хэтрэлтэд тооцогдох алдангийг барагдуулахад хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.

2. Харилцагч байгууллагатай холбоотой асуудал

Гашуун сухайт авто зам ХХК-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2014 оны 29 дүгээр тогтоолоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн харьяанд байгуулахаар шийдвэрлэсэн ч хувьцаа эзэмшигчдийн гэрээнд Эрдэнэс Тавантолгой ХК, Таван толгой ХК, Энержи ресурс ХХК-ийн 2013 оны 12 дугаар 08-ны өдөр байгуулсан гэрээг үндэслэсэн гэж тусгасан. Мөн тус компанийн үйл ажиллагаанаас Эрдэнэс Монгол ХХК-тай байгуулсан гэрээний хүрээнд гарч байгаа зардлын гүйцэтгэл бодитой эсэх талаар нарийвчлан шалгах шаардлагатай байна. Иймд тус компанийн санхүүгийн болон үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтад гүйцэтгэл, нийцлийн аудит хийлгэх саналтай байна.

3. Ногдол ашигтай холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2, 12.9, 12.10 дахь заалтын дагуу тайлант онд нэгдлийн охин компаниудаас 628,493.0 сая төгрөгийн ногдол ашгийг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрч бүртгэснээс үндэсний баялгийн санд төрд ногдох ашиг 411,687.6 сая төгрөгийг төвлөрүүлж, үлдсэн орлогыг стратеги төлөвлөгөөнд тусгасан ирээдүйд орлого, үнэ цэнийг бий болгох бизнес хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалттай байна. Энэ нь Монгол Улсын төсвийн нэгдсэн байх зарчим алдагдаж орлого төвлөрүүлэгч нэгдлийн компани нь татварын бус орлогыг өөртөө төвлөрүүлж, тус компанийн стратеги төлөвлөгөөнд тусгасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх буюу хоёр дахь төсвийг бүрдүүлж зарцуулах нөхцөл байдал үүссэн байна.

4. Төсөлтэй холбоотой асуудал

Компанийн болон охин, хараат компаниудын хэрэгжүүлж буй төслүүдийн талаар нэгдсэн мэдээллийн сан байхгүй, хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтэд үр ашгийн шинжилгээ болон эрсдэлийн үнэлгээ хийгээгүй байна. Мөн хугацаандаа хэрэгжээгүй зогссон үр дүнгээ өгөөгүй төслүүдийн шалтгаан нөхцөлийг судалж, эрсдэлийг бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Эрдэнэс Монгол ХХК нь төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, худалдан авалтын тайлан, санхүүгийн тайлан, хэрэгжилтийн мэдээлэлд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

5. Охин болон хараат компанитай холбоотой асуудал

Нэгдлийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хараат болон охин компаниудын үйл ажиллагаа, эдийн засгийн үр ашигт байдалд гүйцэтгэл, нийцлийн аудит хийх шаардлага үүссэн байна.

6. Охин компанитай холбоотой асуудал

Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн хувьцаа эзэмшигчийн тогтоолоор Эрдэнэс ашид ХХК-ийг Монголын алт ХХК-тай хамтран үүсгэн байгуулсан бөгөөд Гашуун сухайт авто замын тээвэр, Тавантолгой төмөр замын тээврийг хариуцуулах зорилгоор 2024 оны 5 дугаар сарын 07-ны өдөр дахин байгуулсан байна. Тус компани жил бүр алдагдалтай ажилладаг, үйл ажиллагаа нь тогтмол биш байна. Тус компанийг үүсгэн байгуулахтай холбоотой Эрдэнэс Монгол ХХК-аас хөрөнгө оруулалтын зардлыг баталсан бөгөөд 2025 оны 10 дугаар сард хөрөнгө оруулалтын санхүүжилт болох 145,667.0 сая төгрөгийг олгосон байна. Тус компани нь 20 албан хаагчтай бөгөөд тайлант оны 11 сарын байдлаар санхүүжилтийн эх үүсвэр байхгүй цаашид хаанаас хэрхэн санхүүжигдэх нь тодорхойгүй нөхцөл үүссэн байна.

7. Бүтэц орон тоотой холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ыг шинэчлэн баталж, нийт орон тооны дээд хязгаарыг 159 байхаар тогтоосон байна. 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар Олон нийттэй харилцах мэргэжилтэн, Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч (2 орон тоо), Захиргаа, үйлчилгээний хэлтсийн менежер, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хууль, хүний нөөцийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нэгдсэн стратеги, бизнес хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нийт 8 удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан түр тушаалаар томилогдсон байна. Иймд дээрх албан хаагчдыг холбогдох хууль, журамд нийцүүлэн томилсон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Найдваргүй авлагын нөөцтэй холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 76 тогтоолоор Эрдэнэс Монгол нэгдлийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, найдваргүй авлагын нөөцийг хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын нөөц матриц аргаар буюу хугацаа хэтрээгүй 0.4 хувь, 1-30 өдөр хэтэрсэн 1.8 хувь, 31-60 өдөр хэтэрсэн 3.9 хувь, 61-90 өдөр хэтэрсэн 7.6 хувь, 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн 11.1 хувь байхаар тусгасан боловч тайлант онд өмнөх бодлогын баримт бичигт заасан хувь, хэмжээгээр найдваргүй авлагын нөөц байгуулсан байна. Иймд найдваргүй авлагын нөөц байгуулахтай холбоотой асуудлуудыг дараагийн шатны аудитаар авч үзэн, нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 336.5 сая төгрөгийн 1 алдаа² илэрснийг аудитын явцад залруулсан.

5.1.1 Залруулсан алдаа

Сөүл дэх төлөөлөгчийн газрын албан байр, 2 ажилтны амьдрах орон сууц, авто машины түрээсийн урьдчилгаа 336.5 сая төгрөгийг харилцагч бүрээр барьцааны авлага үүсгэж бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

Аудитаар нийт 43,986.4 сая төгрөгийн 27 зөрчил³ илэрсэнд, 69.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 40,993.8 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 2,922.7 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 43,986.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 1,131.1 сая төгрөгөөс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1: Эрдэнэс Монгол ХХК-ийн Захиргаа удирдлагын газрын даргын албан тушаалд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 3 сарын туршилтын хугацаагаар томилогдсон албан хаагчид “Гүйцэтгэлийн удирдлагын журам”-д заасан аргачлалыг мөрдөөгүйгээс 6.4 сая төгрөгийн урамшуулал илүү олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.2.6 “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” 20.8-д “Ажил олгогч ажилтны үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр төлөвлөж, гүйцэтгэлийг сар, улирал, хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнд тохирсон цалин олгох ба энэ харилцааг Гүйцэтгэлийн удирдлагын журмаар зохицуулна”, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/112 тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн удирдлагын журам”-ын 4.9 “Ажилтан урамшууллын хамрах хугацааны 30 хувиас дээш хугацаанд байгууллагад ажилласан бол ажилласан сараар гүйцэтгэлийн хувь тооцож урамшуулалд хамруулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид илүү олгосон үр дүнгийн урамшуулал 6.4 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт-2: Тайлант онд сахилгын шийтгэл ногдуулсан 9 ажилтанд нийт 63.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” 22 дугаар зүйлийн 22.7 “Сахилгын шийтгэл ногдуулсан хугацаанд урамшуулал, дэмжлэг олгогдохгүй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад олгосон үр дүнгийн урамшуулал 63.5 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Эрдэнэс Монгол ХХК нь компанийн дүрэмдээ эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зээл олгох, зээл авах, зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулах, баталгаа болон батлан даалт гаргах эрхийг тусган батлуулсан бөгөөд орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай ажиллаж байгаа хараат болон охин компаниудад зээлийн санхүүжилт олгож, зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж, насжилт өндөртэй найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тус компани 2011 оноос хойш 11 охин, 1 хараат компанид нийт 142,414.4 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөл бүхий зээлийн санхүүжилт олгож, үүнээс 35,297.3 сая төгрөгийн хүүний авлага үүссэн байна. Мөн өмнөх жилүүдэд олгосон зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байхад тайлант онд дахин 6 компанид 18,666.1 сая төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон, өмнөх аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Хуульд өөрөөр заагаагүй бол компани нь зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ”, 84 дүгээр зүйлийн 84.4.2 “Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хуулийн болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай хараат болон охин компаниудад зээлийн санхүүжилт олгож, зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг

нэмэгдүүлж, насжилт өндөртэй найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бүрдүүлж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-2: Тайлант хугацаанд охин болон хараат компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн гэрээний хугацаа дууссан байхад зээлийн үндсэн төлбөр 15,540.2 сая төгрөг, хуримтлагдсан хүү 1,061.2 сая төгрөг, нийт 16,601.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2 "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", Иргэний тухай хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1 "зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдүүлэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрлийн, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хараат болон охин компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, хугацаандаа эргэн төлөгдөөгүйгээс үүссэн үндсэн төлбөрийн болон хүүний авлагыг барагдуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-3: Эрдэнэс монгол нэгдлийн хэмжээний хараат, охин компаниас зөвхөн 7 компаниаг менежментийн үйлчилгээний гэрээ байгуулж, тайлант онд 3 компаниас 55,835.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь нэгдлийн хэмжээний охин, хараат компаниудад менежментийн үйлчилгээг нэгдсэн байдлаар жигд, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлээгүй байна.

Мөн менежментийн төлбөрийн хувь, хэмжээ, өртөг тооцсон талаар нарийвчилсан тооцоололгүй, хувь хэмжээг ялгаатай тогтоосон, орлогын бүртгэлийн талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тодорхой тусгаагүй, борлуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг тооцож, хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.12 "Толгой компани нь үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд хараат болон охин компанийн үйл ажиллагаанд зөвхөн эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээр оролцоно", 84 дүгээр зүйлийн 84.4.2 "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэгдлийн хэмжээний охин, хараат компаниудад менежментийн үйлчилгээг нэгдсэн байдлаар жигд, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлдэггүй орлогын бүртгэлийн талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт

тодорхой тусгаагүй, борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцож, хүлээн зөвшөөрч бүртгэдэггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-4: Эрдэнэс Монгол ХХК нь гадаад дахь төлөөлөгчийн газруудын оффис, ажилтнуудын орон сууц, авто машины түрээсийн төлбөрийн норм, нормативыг тогтоогоогүй бөгөөд ашиглаж буй байрны талбай нь Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад мөрдөгддөг дундаж талбайн нормтой харьцуулахад талбайн хэмжээ илүү байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2 "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3 "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрдэнэс Монгол ХХК нь гадаад дахь төлөөлөгчийн газруудын оффис, ажилтнуудын орон сууц, авто машины түрээсийн төлбөрийн норм, нормативыг тогтоогоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-5: Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 03 дугаар тогтоолоор Эрдэнэс Ассет Менежмент ҮЦК ХХК-ийг техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаагүйгээр үүсгэн байгуулж, 2023 онд татан буулгасан бөгөөд 2019–2023 онд хуримтлагдсан 1,477.2 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийн авлага, 223.4 сая төгрөгийн хүүний авлага, нийт 1,700.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, авлага барагдуулах талаар зохих арга хэмжээ аваагүй, авлагыг хэрхэн шийдвэрлэх талаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байхад 2024 оны санхүүгийн тайланд хуримтлагдсан ашиг (алдагдал)-ын дансанд хааж бүртгэсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Компанийг татан буулгах үед түүний өр төлбөрийг барагдуулахдаа Иргэний хууль, энэ хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө", 27.2 "Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлэх бөгөөд нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байна", 27.3 "Татан буулгах комисс нь компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг зээлдүүлэгчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй", 27.10 "Татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн зээлдүүлэгчдийн өр төлбөрийг татан буулгах балансыг баталсан өдрөөс эхлэн тус балансын дагуу Иргэний хууль болон энэ хуульд заасан дарааллын дагуу барагдуулна", Иргэний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 "Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ", 32.6 "Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална", 281 дүгээр зүйлийн 281.1 "зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдүүлэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрлийн, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ", 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Эрдэнэс Монгол ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 8 дугаар тогтоолоор "Компани татан буулгах тухай" 02 дугаар хавсралт Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгах комиссын журмын 1 "Татан буулгах комиссын өр төлбөр барагдуулах хугацаа 2 сар байна", 5 "Татан буулгах комисс нь компанийн бусдын өмнө хүлээсэн аливаа үүрэг, өр төлбөр, бусдаас авах авлага байвал хэрхэн шийдвэрлэх саналыг хувьцаа эзэмшигчид танилцуулж шийдвэр гаргуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр

тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн санхүүжилтийн авлагыг барагдуулаагүй, авлага барагдуулах талаар зохих арга хэмжээ аваагүй, авлагыг хэрхэн шийдвэрлэх талаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байхад хуримтлагдсан ашиг дансанд хааж бүртгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-6: Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 64 дүгээр хуралдааны тэмдэглэл, Эрдэнэс Монгол ХХК болон Эйкусора ХХК-ийн хооронд 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан гэрээг үндэслэн Эрдэнэс Шивээ Энержи ХХК, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 19 дүгээр тогтоол, Эрдэнэс Монгол ХХК болон МСХ Клиринг ХХК-ийн хооронд байгуулсан гэрээг үндэслэн Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийг тус тус үүсгэн байгуулсан байна.

Дээрх компаниудыг үүсгэн байгуулахдаа техник, эдийн засгийн үндэслэл, эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгааг боловсруулаагүй, байгуулагдсан цагаасаа эхлэн алдагдалтай ажилласан бөгөөд Эрдэнэс Монгол ХХК-аас олгосон зээлийн санхүүжилтийн 1,068.2 сая төгрөгийн үндсэн зээлийн авлага, 536.8 сая төгрөгийн хуримтлагдсан хүүний авлага, нийт 1,605.0 сая төгрөгийн авлагыг хэрхэн барагдуулах, эргэн төлүүлэх нь тодорхойгүй болж, найдваргүй авлага үүсэх эрсдэл бий болсон байна.

Мөн дээрх компаниудыг татан буулгах үүрэг, чиглэл өгсөн боловч татан буулгах комисс уг шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж, ямар шийдвэр гаргасан нь тодорхойгүй, анхан шатны баримт, материалын бүрдэл хангалтгүй, баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 “Дампуурсан буюу техник, технологи нь хоцрогдсон, цаашид өөрчлөн шинэчилсэн ч эдийн засгийн үр ашиггүй нь тогтоогдсон төрийн өмчит үйлдвэрийн газрыг Засгийн газрын шийдвэрээр татан буулгаж өрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг хувьчилж болно”, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2 “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компани татан буулгах комисс журмын дагуу ажиллаагүй, ямар шийдвэр гаргасан нь тодорхойгүй, анхан шатны баримт, материалын бүрдэл хангалтгүй, холбогдох авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-7: Зээлийн санхүүжилтийн гэрээнд үндсэн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн төлөгдөөгүй үндсэн төлбөрийн дүнгээс гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд нэмэгдүүлсэн хүү тооцохоор заасан боловч хүү тооцоогүй байна.

Тайлант онд охин болон хараат гурван компанийн хугацаандаа төлөгдөөгүй нийт 15,121.0 сая төгрөгийн үндсэн төлбөрт ногдох 756.4 сая төгрөгийн нэмэгдүүлсэн хүүг тооцоогүй, холбогдох авлагыг бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2 “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, Иргэний тухай хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1 “зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдүүлэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрлийн, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ”, 453 дугаар зүйлийн 453.1 “Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй”, Зээлийн санхүүжилтийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.3 “Зээлийн хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг төлөөгүй бол зээлийн хуваарьт өдрийн дараагаас эхлэн тухайн төлөөгүй үндсэн төлбөрийн дүнгээс гэрээний үүргээ биелүүлж дуусах хүртэлх хугацаанд гэрээнд заасан хувиар нэмэгдүүлсэн хүүг тооцно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хараат болон охин компанитай байгуулсан гэрээнд заасан нэмэгдүүлсэн хүү тооцоогүй, гэрээний заалтыг мөрдөөгүй, гэрээний хугацаа дууссан байхад хэрэгжилтийг дүгнэдэггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-8: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны “Компанийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” 40 дүгээр тогтоолоор компанийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхардсан чиг үүрэг бүхий Хяналтын асуудал хариуцсан менежер, Чанар, бүтээмжийн асуудал хариуцсан менежер, Дижитал шилжилт хариуцсан менежер, Хариуцлагатай уул уурхайн асуудал хариуцсан менежерийн албан тушаалуудыг баталж, үндсэн цалинг 12.0–14.2 сая төгрөгөөр тогтоосон, компанийн засаглал хариуцсан менежерийн албан тушаалыг шинээр бий болгож, үндсэн цалинг 14.0 сая төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд нийт 1,073.0 сая төгрөгийн цалин, нэмэгдэл олгосон нь компанийн бүтэц зохион байгуулалт уялдаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.2 чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.2.6 “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн бүтэц зохион байгуулалттай уялдаагүй, удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхардсан чиг үүрэг бүхий менежерүүдийг томилж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-9: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн нарийн бичгийн даргын нийт гурван удаагийн албан бичгийг үндэслэн гадаад албан томилолтын онгоцны билетийн зардалд 70.8 сая төгрөг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2 зөвлөхийн гадаад албан томилолтын зардалд 12.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дүрмийн 12 дугаар зүйлийн 12.3 “Төрийн албан хаагчийн хувьд Хэрэг эрхлэх газарт харьяалагдах улс төрийн албан тушаалтны дотоод, гадаад албан томилолтын асуудлыг Хэрэг эрхлэх газрын дарга шийдвэрлэнэ”,

Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/126 тушаалаар баталсан "Эрдэнэс Монгол ХХК-ийн ажилтнуудын албан томилолтоор ажиллах журам"-ын 2.1.4 "Ажилтан гэж компанид хөдөлмөрийн гэрээгээр үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн компанид хамааралгүй албан хаагчдад холбогдох хууль, журам зөрчин томилолтын зардал олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-10: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 29.0 сая төгрөг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, ажлын албаны хурал зөвлөгөөний ажлын хэрэгцээнд 16.5 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттай зохион байгуулах", 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж тус тус заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин бэлэг дурсгалын зүйл худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-11: Өмнөх онд компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлахтай холбоотой ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн 4 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 111.1 төгрөгийг компаниас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, тайлант онд нэмж 8 ажилтанд 350.9 сая төгрөгийг компаниас олгосон, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 4.2.9. энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын хохирлыг байгууллагаас төлснийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх арга хэмжээ авч, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-12: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн “Компанийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах, үйл ажиллагаандаа ашигладаггүй 8,715.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй нүүрс экспортлох гаалийн үзлэгийн зориулалттай 33,402 м2 бетон хучилттай үзлэгийн зам талбайг санхүүгийн тайланд тусгаж хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй, мөн Гашуун сухайт авто замыг дагасан боомтын дэд бүтцийн 28 нэр төрлийн 2,978.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж зөвшөөрөл авахгүй нурааж, цаашид ашиглах боломжгүй болгосон” зөрчлийг арилгах аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 67.2 “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1 “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-13: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн “гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, үүрэгт ажлаас нь чөлөөлөх тушаалын дагуу өмнөх гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ажлаас чөлөөлж, 8 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 96.0 сая төгрөгийг тэтгэмжийг олгохдоо ажилтнаас авах 16.1 сая төгрөгийн авлагыг суутгаагүй” зөрчлийг арилгах аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаа нь өмнө хянан баталгаажуулах”, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2 “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1 “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-14: Тус компани нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын

байгууллагад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн хавсралтад дурдсан албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”, 42 дугаар зүйлийн 42.2 “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй бүртгэл тайлагналын хэлтсийн менежер, ерөнхий нягтлан бодогчид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хараат компанитай холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК нь Гашуунсухайт авто зам ХХК-тай "Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн авто замын ашиглалт, үйлчилгээ, засвар арчилгааг гүйцэтгэх гэрээ"-г 2014 оноос байгуулан, өөрийн эзэмшлийн 239 км хүнд даацын хатуу хучилттай авто зам, замын барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, арчлалт, урсгал болон их засварын ажлыг зохион байгуулах, зам ашигласны төлбөрийг төвлөрүүлэх ажлыг гүйцэтгүүлж байгаа бөгөөд гэрээний харилцаатай холбоотойгоор дараах эрсдэл бүхий асуудлууд үүссэн байна. Үүнд:

- Гашуунсухайт авто зам ХХК-ийг 3 хуулийн этгээд хамтран үүсгэн байгуулсан бөгөөд компани үүсгэн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн гэрээнд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах журам, үүсгэн байгуулагч тус бүрийн хүлээх үүрэг зэргийг нарийвчлан тусгаагүй, үүнээс шалтгаалан компаниудын эрх үүрэг тодорхойгүй;
- Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн 40.0 хувийн оролцоо бүхий хараат компанитайгаа шууд гэрээ байгуулан, ажил үйлчилгээ гүйцэтгүүлж байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулиудтай зөрчилдсөн, тайлант онд 12,176.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн;
- Авто замын ашиглалт, үйлчилгээ, засвар арчилгааг гүйцэтгэх гэрээнд ажлын даалгаврыг тодорхой байдлаар тусгаагүй, өртөг зардал хамгийн зохистой түвшинд байгаа эсэхийг тооцоолсон баримтгүй байна. Тус компанийн ТУЗ-өөс Гашуун сухайт авто зам ХХК-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталдаг бөгөөд энэ нь хамтарсан компани буюу хувийн өмчийн оролцоотой, хувь нийлүүлсэн компанийн үйл ажиллагаанд хувь оролцооны байдлаар бус, шууд байдлаар оролцсон;
- Гэрээний хугацааг 2014 оноос эхлэн 5 жил, сунгалт 2 жил байхаар тохирсон боловч 2025 оны байдлаар, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, хугацааг тодорхойгүй байхаар тусгасан;
- Гашуун сухайт авто зам ХХК-ийн нийт хувьцааны 40.0 хувийг Эрдэнэс Таван толгой ХК, 20.0 хувийг Таван толгой ХК, 40.0 хувийг Энержи ресурс ХХК тус тус

эзэмшиж байгаа бөгөөд санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгүүлдэггүй, санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй;

Энэ нь Компанийн тухай хуулийн 13.3 "Компанийг нэгээс дээш этгээд үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчид нь компани үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулж болох бөгөөд уг гэрээнд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах журам, үүсгэн байгуулагч тус бүрийн хүлээх үүрэг, тэдгээрийн худалдан авах хувьцаа болон бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгана", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1 "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 7.1 "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.3 "Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн", 7.1.5 "энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто замын ашиглалт, үйлчилгээ, засвар арчилгааг гүйцэтгүүлэхтэй холбоотой ажлыг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулж, дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

2. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн эзэмшлийн MV-13311, MV-13312 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг шилжүүлэн ашиглуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт бүрдээгүй, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад 2009 оноос эхлэн Шивээ Овоо ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээг жил бүр сунган тус талбайд нүүрс олборлуулсаар байна. Гэрээний зорилгыг Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцуудын нүүрсний хэрэгцээг хангах зайлшгүй шаардлагын хүрээнд Шивээ Овоо ХК-ийн гаргасан хүсэлт, тухайн үеийн ЭБЭХЯ-аас өгсөн чиглэлийн дагуу нүүрс олборлох гэж тодорхойлж байсан бөгөөд гэрээг жил бүр шинэчлэн, 2024 оноос эхлэн гэрээний зорилгыг нүүрс олборлон, сар бүр төлбөр төлөхтэй холбоотой харилцааг зохицуулах гэж тодорхойлсон байна.

Шивээ Овоо ХК-ийн нийт хувьцааны 90.0 хувийг төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч Эрдэнэс Монгол ХХК, 10.0 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшдэг байна. Шивээ овоо ХК-ийн эзэмшлийн MV-000901 тусгай зөвшөөрлийн талбайн ашиглалтын нөөц дуусаж, 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 8.0 сая тонн үлдэгдэл нөөцтэй гэж тайлагнагдсан байна.

Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн эзэмшлийн MV-021484 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг шилжүүлэн ашиглуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт бүрдээгүй, эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гараагүй байхад хувьцааны 25.0 хувийг олон нийт эзэмшдэг Багануур ХК-д ямар нэгэн гэрээ, хэлэлцээр байгуулахгүйгээр нүүрс олборлуулсаар байна.

Багануур ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус компанийн нийт хувьцааны 75.0 хувийг төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч Эрдэнэс Монгол ХХК, 21.06 хувийг Монголиан коал корпорейшн ХХК, 3.94 хувийг аж ахуйн нэгж, хувь хүмүүс эзэмшиж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл "Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрх 9.2/ төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох, 9.3/ төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах", 9¹ дүгээр зүйл. "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага. 9^{1.1} "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн", 11 дүгээр зүйл. "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй: 11.1/төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах", 21 дүгээр зүйлийн 21 "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно", Засгийн газрын 2023 оны 108 дугаар тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн 1.2 дахь хэсгийн 1.2.3 "Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна..

Өгсөн зөвлөмж: Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг ашиглуулахтай холбоотой гэрээний харилцааг холбогдох хууль, журамд нийцүүлэх, төрийн өмчийн ордыг хувьцаат компанид ашиглуулахад гарч болзошгүй эрсдэлийг тооцож, ашиглалтын үр дүн, ашгийн хуваарилалт, хяналтын тогтолцоог тодорхой болгох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 220 нэр төрлийн 2,740.4 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ аваагүй байна. Тухайлбал:

- Тооллогын комиссын дүгнэлтээр тайлант оны үлдэгдэл өртөггүй 1,624.8 сая төгрөгийн 66 нэр төрлийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасуулахаар шийдвэрлэсэн боловч байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргаагүй;
- Өмнөх жилүүдэд буюу 2023–2025 онуудад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,115.6 сая төгрөгийн 154 нэр төрлийн хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоогоогүй, бодит үнэ цэнээр бүртгээгүй зэрэг нь хөрөнгийн бодит үнэ цэнэ, дансны бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах, хөрөнгийн үр ашиг буурах зэрэг эрсдэлүүдийг үүсгэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх", 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", 31.1.3 "засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах", 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит

хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", 7.2 "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 10 дугаар зүйлийн 10.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.9 "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Компанийн дүрмийн 5.1.2 "Компанийн санхүүгийн жил 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг акталж данснаас хасах, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, бодит үнээр үнэлж, бүртгэх, тайлагнах ажлыг санхүүгийн жилд багтаан дотооддоо зохион байгуулж, холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлж байх.

4. Биологийн хөрөнгөтэй холбоотой асуудал

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Шинэ Хархорум хотын төлөвлөлтөд тусгагдсан ногоон байгууламж, ойн зурвас байгуулах зорилтыг хангаж орон зайн оновчтой төлөвлөлтөөр экосистем, эдийн засгийн үр ашигтайгаар мод тарьж арчилж ургуулах зорилгын хүрээнд тайлант онд 2,134.5 сая төгрөгийн 21.0 мянган ширхэг навчит, 9.0 мянган ширхэг шилмүүст мод тарьсныг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 108 тоот тогтоолоор баталсан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 5.2.3 Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд дотоод хяналт тавих зорилгоор дотоод аудитын нэгж нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд ажиллана. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмч хөрөнгөд тавих хяналтыг сайжруулж, шилмүүст болон навчит модны өртөг, зардлыг бодитой тооцоолж, хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх боломжтой эсэхийг стандартад нийцүүлэн үнэлж, бүртгэх, тайлагнах ажлын зохион байгуулах.

5. Зардлын данстай холбоотой асуудал

Эрдэнэс Монгол ХХК нь Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт 2.41 га талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд "Хайгуул ба үнэлгээний үе шат"-ны хээрийн судалгааны ажилтай холбогдуулан 2016-2022 онд гарсан 567.6 сая төгрөгийн зардлыг холбогдох стандартад нийцүүлэн ангилж бүртгээгүйгээр уул уурхайн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 409 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар "Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох

бүртгэлийн стандарт"-ын 4.2.2.1 "Аж ахуйн нэгж ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандарт, НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнээс бусад хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлыг СТОУС 6 "Ашигт малтмалын нөөцийн хайгуул, үнэлгээ" стандартад нийцүүлэн тусгай зөвшөөрөл бүрээр НББ-дээ хөрөнгөөр бүртгэх, эсвэл зардал гарсан үед ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэх гэсэн аргуудаас аль нэгийг сонгон нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тодорхойлно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Уул уурхайн хөрөнгөнд бөөн дүнгээр бүртгэсэн хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг холбогдох нотлох анхан шатны баримт, шийдвэрт үндэслэн НББОУС 16, НББОУС 38, СТОУС 6 стандартад нийцүүлэн бүртгэж, тайлагнах ажлыг зохион байгуулах.

6. Уул уурхайн хөрөнгөтэй зардалтай холбоотой асуудал

"Эрдэнэс Монгол" ХХК нь Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумын нутагт 270 га талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд ашигт малтмалын нөөцийн үйлдвэрлэлийн зэрэг тогтоох "Хайгуул ба үнэлгээний үе шат"-ны ажилтай холбогдуулан 2016-2022 онд гарсан 214.3 сая төгрөгийн зардлыг холбогдох стандартад нийцүүлэн ангилж бүртгээгүйгээр, уул уурхайн хөрөнгө дансанд бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 409 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар "Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт"-ын 4.2.2.1 "Аж ахуйн нэгж ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандарт, НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнээс бусад хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлыг СТОУС 6 "Ашигт малтмалын нөөцийн хайгуул, үнэлгээ" стандартад нийцүүлэн тусгай зөвшөөрөл бүрээр НББ-дээ хөрөнгөөр бүртгэх, эсвэл зардал гарсан үед ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэх гэсэн аргуудаас аль нэгийг сонгон нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тодорхойлно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Уул уурхайн хөрөнгөнд бөөн дүнгээр бүртгэсэн хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг холбогдох нотлох анхан шатны баримт, шийдвэрт үндэслэн НББОУС 16, НББОУС 38, СТОУС 6 стандартад нийцүүлэн бүртгэж, тайлагнах ажлыг зохион байгуулах.

7. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

Ухаа худгаас Гашуун сухайт боомт чиглэлийн хатуу хучилттай замын зориулалтын 21.9 сая м.кв газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 2 "Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэний бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна. Биет бус хөрөнгийг дараах байдлаар ангилна...(е)Газар эзэмших эрх", Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол 2024

оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 76 дугаар тогтоолоор баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах тухай" нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.13.6 "Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилтэд газар эзэмших эрхэд дахин үнэлгээний загвар" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, холбогдох эрх байгууллагаар шийдвэр гаргуулан санхүүгийн тайланд толилуулж, тодруулах.

8. Зардлын данстай холбоотой асуудал

Компанийн удирдлагууд хот дотор суудлын автомашин ашиглаж нийт 6.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн удирдлагууд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу хот дотор суудлын автомашин ашиглахгүй байх.

9. Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал

Гашуун Сухайт ХХК-ийн эзэмшлийн 251.0 сая төгрөгийн өртөг бүхий Toyota LC (01-88 УБЕ), 230.0 сая төгрөгийн өртөг бүхий Nissan Patrol (21-93 УББ), 115.0 сая төгрөгийн өртөг бүхий Nissan 461 (70-83 УБЧ) гэсэн гурван суудлын автомашиныг 2018, 2019 оноос эхлэн Эрдэнэс Монгол ХХК-ийн дотоод үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд эдгээр автомашинуудыг шилжүүлэн ашиглуулахтай холбоотой эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, мөн компани хоорондын зохицуулалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компани хооронд хөрөнгө шилжүүлэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж, мөрдөж ажиллах.

10. Цагийн бүртгэлтэй холбоотой асуудал

Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системийн мэдээллийн сангаас түүвэрлэн тулган шалгахад, зарим албан хаагчид системд бүртгүүлээгүй, мөн салбар төлөөлөгчийн газрын албан хаагчдын цагийн бүртгэл системд холбогдоогүйгээс гараар бүртгэдэг зэрэг нь цагийн бүртгэлийн системд тавих хяналт сул байгааг харуулж байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй", Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/24 дугаар "Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн

батлах тухай" тушаалын 13.5 "Ажилтан журмын 13.4 дэх хэсэгт заасан ажлын цагт Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн ажил үүргийг гүйцэтгэх ба цаг ашиглалтын байдалд нэгжийн удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хяналт тавина", 17 дугаар зүйлийн 17.3 "Ажилтны цаг бүртгэх төхөөрөмжид бүртгэгдсэн цаг нь тухайн ажилтанд цалин хөлс, шагналт цалин, бусад нэмэгдэл олгох, суутгал хийх баримт болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын цаг бүртгэлийн системд бүх албан хаагчдыг хамруулж, цаг ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх.

11. Тайлан тодруулгатай холбоотой асуудал

Компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (СТ-1–СТ-5 маягт)-ыг ирүүлэхдээ тайлангийн толилуулга, тодруулга, нэмэлт мэдээлэл, мөн шаардлагатай шинжилгээ, тайлбар мэдээллийг бэлтгээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлага, мөн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд зориулсан ил тод, бүрэн мэдээлэх зарчмыг хангахгүйгээс гадна хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл хүргэхэд эрсдэл үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2017 оны "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" 361 дугаар тушаалын хавсралтын 5 дах "Санхүүгийн тайлангийн толилуулга. Аж ахуйн нэгж нь дараах мэдээллийг толилуулна. Үүнд: 1 "Тайлагнагч аж ахуйн нэгжийн нэр, өмнөх тайлант үеийн эцсийн мэдээлэл дэх аливаа өөрчлөлт", 2 "Санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлан болох тухай", 3 "Тайлант үеийн эцсийн өдөр, санхүүгийн тайлан эсхүл тодруулгын хамрах хугацаа", 4 "Толилуулгын валют санхүүгийн тайлангийн тодруулга", 6 "Аж ахуйн нэгж нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн бэлтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сөүл дэх төлөөлөгчийн газрын албан байр, 2 ажилтны амьдрах орон сууц, авто машины түрээсийн урьдчилгааг харилцагч бүрээр барьцааны авлага үүсгэж бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.	1	336,462.6	-	-	1	336,462.6	1	336,462.6	-	-	-	-
Нийт дүн	1	336,462.6	-	-	1	336,462.6	1	336,462.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Эрдэнэс Монгол ХХК-ийн Захиргаа удирдлагын даргын албан тушаалд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 3 сарын туршилтын хугацаагаар томилогдсон албан хаагчид гүйцэтгэх захирлын 2025 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн удирдлагын журам"-д заасан аргачлалыг мөрддөггүйгээс 6.4 сая төгрөгийг илүү олгосон байна.	1	6,396.8	1	6,396.8	-	-	-	-	-	-
2	Тайлант онд сахилгын шийтгэл ногдуулсан 9 ажилтанд нийт 63.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	63,477.5	1	63,477.5	-	-	-	-	-	-
3	Өмнөх жилүүдэд олгосон зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байхад тайлант онд дахин 6 компанид 18,666.1 сая төгрөгийн зээлийн	1	18,666,096.7	-	-	1	18,666,096.7	-	-	-	-

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	санхүүжилт олгосон, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.										
4	Тайлант хугацаанд охин болон хараат компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн гэрээний хугацаа дууссан байхад зээлийн үндсэн төлбөр 15,540.2 сая төгрөг, хуримтлагдсан хүү 1,061.2 сая төгрөг, нийт 16,601.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг аваагүй байна.	1	16,601,468.0	-	-	1	16,601,468.0	-	-	-	-
5	Эрдэнэс монгол нэгдлийн хэмжээний нийт 42 хараат, охин компаниас зөвхөн 7 компанитай менежментийн үйлчилгээний гэрээ байгуулж, тайлант онд 3 компаниас 55,835.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь нэгдлийн хэмжээний охин, хараат компаниудад менежментийн үйлчилгээг нэгдсэн байдлаар жигд, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
6	Эрдэнэс Монгол ХХК нь гадаад дахь төлөөлөгчийн газруудын оффис, ажилтнуудын орон сууц, авто машины түрээсийн төлбөрийн норм, нормативыг тогтоогоогүй бөгөөд ашиглаж буй байрны талбай нь Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад мөрдөгддөг дундаж талбайн нормтой харьцуулахад талбайн хэмжээ илүү байна	1	-	-	-	1	-	-	-	-	-
7	Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 03 дугаар тогтоолоор “Эрдэнэс Ассет Менежмент” ҮЦК ХХК-ийг техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаагүйгээр үүсгэн байгуулж, 2023 онд татан буулгасан бөгөөд 2019–2023 онд хуримтлагдсан 1,477.2 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийн авлага, 223.4 сая төгрөгийн хүүний авлага, нийт 1,700.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, авлага барагдуулах талаар зохих арга хэмжээ аваагүй, авлагыг хэрхэн шийдвэрлэх талаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байхад 2024 оны санхүүгийн тайланд хуримтлагдсан ашиг (алдагдал)-ын дансанд хааж бүртгэсэн байна.	1	1,700,610.3	-	-	1	1,700,610.3	-	-	-	-
8	Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийг үүсгэн байгуулахдаа техник, эдийн засгийн үндэслэл, эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгааг боловсруулаагүй, байгуулагдсан цагаасаа эхлэн алдагдалтай ажилласан бөгөөд Эрдэнэс Монгол	1	1,605,016.1	-	-	1	1,605,016.1	-	-	-	-

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	ХХК-аас олгосон зээлийн санхүүжилтийн 1,068.2 сая төгрөгийн үндсэн зээлийн авлага, 536.8 сая төгрөгийн хуримтлагдсан хүүний авлага, нийт 1,605.0 сая төгрөгийн авлагыг хэрхэн барагдуулах, эргэн төлүүлэх нь тодорхойгүй болж, найдваргүй авлага үүсэх эрсдэл бий болсон байна.										
9	Тайлант онд охин болон хараат гурван компанийн хугацаандаа төлөгдөөгүй нийт 15,121.0 сая төгрөгийн үндсэн төлбөрт ногдох 756.4 сая төгрөгийн нэмэгдүүлсэн хүүг тооцоогүй, холбогдох авлагыг бүртгэж тайлагнаагүй байна.	1	756,360.0	-	-	1	756,360.0	-	-	-	-
10	Таван асуудал хариуцсан менежерийн албан тушаалыг шинээр бий болгож, үндсэн цалинг 14.0 сая төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд нийт 1,073.0 сая төгрөгийн цалин, нэмэгдэл олгосон нь компанийн бүтэц зохион байгуулалт уялдаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна.	1	1,073,044.8	-	-	1	1,073,044.8	-	-	-	-
11	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн нарийн бичгийн даргын нийт 3 удаагийн албан бичгийг үндэслэн Улсын Их Хурлын 6 гишүүний гадаад албан томилолтын онгоцны билетийн зардалд 70.8 сая төгрөг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2 зөвлөхийн гадаад албан томилолтын зардалд 12.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	83,660.9	-	-	1	83,660.9	-	-	-	-
12	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 29.0 сая төгрөг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, ажлын албаны хурал зөвлөгөөний ажлын хэрэгцээнд 16.5 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан байна	1	45,555.0	-	-	1	45,555.0	-	-	-	-
13	Өмнөх онд компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлахтай холбоотой ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн 4 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 111.1 сая төгрөгийг компаниас олгосонд төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй, тайлант онд нэмж 8 ажилтанд 350.9 сая төгрөгийг компаниас олгосон байна.	1	462,019.5	-	-	1	462,019.5	-	-	-	-
14	Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар “Компанийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах, үйл ажиллагаандаа ашигладаггүй 8,715.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй нүүрс экспортлох гаалийн үзлэгийн зориулалттай 33,402 м2 бетон	1	-	-	-	1	-	-	-	-	-

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	хучилттай үзлэгийн зам талбайг санхүүгийн тайланд тусгаж хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.										
15	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ажлаас чөлөөлж, 8 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 96.0 сая төгрөгийг тэтгэмжийг олгохдоо ажилтнаас авах 16.1 сая төгрөгийн авлагыг суутгаагүй” зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй, хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
16	Тус компани нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн хавсралтад дурдсан албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-
17	Эрдэнэс Монгол ХХК нь Гашуунсухайт авто зам ХХК-тай "Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн авто замын ашиглалт, үйлчилгээ, засвар арчилгааг гүйцэтгэх гэрээ"-г 2014 оноос байгуулан, өөрийн эзэмшлийн 239 км хүнд даацын хатуу хучилттай авто зам, замын барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, арчлалт, урсгал болон их засварын ажлыг зохион байгуулах, зам ашигласны төлбөрийг төвлөрүүлэх ажлыг гүйцэтгүүлж байгаа бөгөөд гэрээний харилцаатай холбоотойгоор дараах эрсдэл бүхий асуудлууд үүссэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
18	Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн эзэмшлийн MV-13311, MV-13312 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг шилжүүлэн ашиглуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт бүрдээгүй, эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад 2009 оноос эхлэн Шивээ Овоо ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээг жил бүр сунган тус талбайд нүүрс олборлуулсаар байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
19	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 220 нэр төрлийн 2,740.4 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ аваагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

20	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Шинэ Хархорум" хотын төлөвлөлтөд тусгагдсан ногоон байгууламж, ойн зурвас байгуулах зорилтыг хангаж орон зайн оновчтой төлөвлөлтөөр экосистем, эдийн засгийн үр ашигтайгаар мод тарьж арчилж ургуулах зорилгын хүрээнд тайлант онд 2,134.5 сая төгрөгийн 21.0 мянган ширхэг навчит, 9.0 мянган ширхэг шилмүүст мод тарьсныг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн нь стандартын дагуу хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэх, мөн төрийн өмч хөрөнгөд тавих хяналт алдагдах эрсдэлтэй байна.	1	2,134,532.2	-	-	-	-	1	2,134,532.2	-	-
21	Эрдэнэс Монгол ХХК нь Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт 2.41 га талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд "Хайгуул ба үнэлгээний үе шат"-ны хээрийн судалгааны ажилтай холбогдуулан 2016-2022 онд гарсан 567.6 сая төгрөгийн зардлыг холбогдох стандартад нийцүүлэн ангилж бүртгээгүйгээр, уул уурхайн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.	1	567,595.6	-	-	-	-	1	567,595.6	-	-
22	"Эрдэнэс Монгол" ХХК нь Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумын нутагт 270 га талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд ашигт малтмалын нөөцийн үйлдвэрлэлийн зэрэг тогтоох "Хайгуул ба үнэлгээний үе шат"-ны ажилтай холбогдуулан 2016-2022 онд гарсан 214.3 сая төгрөгийн зардлыг холбогдох стандартад нийцүүлэн ангилж бүртгээгүйгээр, уул уурхайн хөрөнгө дансанд бөөн дүнгээр бүртгэсэн байна.	1	214,290.1	-	-	-	-	1	214,290.1	-	-
23	Ухаа худгаас Гашуун сухайт боомт чиглэлийн хатуу хучилттай замын зориулалтын 21.9 сая м.кв газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
24	Компанийн удирдлагууд хот дотор суудлын автомашин ашиглаж нийт 6.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна.	1	6,304.8	-	-	-	-	1	6,304.8	-	-
25	Гашуун Сухайт ХХК-ийн эзэмшлийн 251.0 сая төгрөгийн өртөг бүхий Toyota LC (01-88 УБЕ), 230.0 сая төгрөгийн өртөг бүхий Nissan Patrol (21-93 УББ), 115.0 сая төгрөгийн өртөг бүхий Nissan 461 (70-83 УБЧ) гэсэн гурван суудлын автомашиныг 2018, 2019 оноос эхлэн Эрдэнэс Монгол ХХК-ийн	1	-	-	-	-	-	1	-	-	-

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	дотоод үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд эдгээр автомашинуудыг шилжүүлэн ашиглуулахтай холбоотой эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, мөн компани хоорондын зохицуулалтгүй байна.										
26	Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системийн мэдээллийн сангаас түүвэрлэн тулган шалгахад, зарим албан хаагчид системд бүртгүүлээгүй, мөн салбар төлөөлөгчийн газрын албан хаагчдын цагийн бүртгэл системд холбогдоогүйгээс гараар бүртгэдэг зэрэг нь цагийн бүртгэлийн системд тавих хяналт сул байгааг харуулж байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
27	Компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (СТ-1–СТ-5 маягт)-ыг ирүүлэхдээ тайлангийн толилуулга, тодруулга, нэмэлт мэдээлэл, мөн шаардлагатай шинжилгээ, тайлбар мэдээллийг бэлтгээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлага, мөн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд зориулсан ил тод, бүрэн мэдээлэх зарчмыг хангахгүйгээс гадна хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл хүргэхэд эрсдэл үүсгэж байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
Нийт дүн		27	43,986,428.3	2	69,874.3	13	40,993,831.3	11	2,922,722.7	1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 918.7 сая төгрөгийн мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн	1	918,751.9	1	918,751.9	-	-
	Дүн	1	918,751.9	1	918,751.9	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	Компани нь эдийн засгийн үр ашиг нь хэзээ гарах нь тодорхойгүй, байгуулагдсан цагаасаа алдагдалтай ажиллаж байгаа компаниудад үр ашгийн шинжилгээ хийгээгүй, алдагдалтай ажилласан шалтгаан нөхцөлийг тодорхойлоогүй, алдагдлыг бууруулах, компаниудыг нэгтгэх, татан буулгах зэрэг арга хэмжээ аваагүй байна.	1	-	1	-	-	-
2	Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг" холбогдох хууль болон журамд заасан цаглаварт хугацаанаас хороож баталсан байна.	1	-	1	-	-	-
3	Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 98.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сургалтуудыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна	1	-	1	-	-	-
4	Тайлант онд 876.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэн батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.	1	876,640.0	1	876,640.0	-	-
5	Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 44 төсөл арга хэмжээнд гэрээний нийт дүнгээр 560.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Мөн тайлант онд он дамжин хэрэгжиж буй зарим төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.	1	560,449.7	1	560,449.7	-	-
6	Тайлант онд 280.0 сая төгрөгөөр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах төсөл, арга хэмжээний төлөвлөгөө баталсан боловч төлөвлөгөөнд туссан төсөвт өртгөөс хэтрүүлж тайлант онд 41 хэвлэл, мэдээллийн байгууллагатай 424.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 484.3 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	280,000.0	1	280,000.0	-	-
7	Тайлант онд шууд худалдан авалтын аргаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актууд байхгүй зөрчил нийтлэг, эдгээр нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.	1	-	1	-	-	-

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

8	Эрдэнэс Монгол ХХК нь нэгдлийн урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулаагүй.	1	-	-	-	1	-
9	Эрдэнэс Монгол ХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдлийн хэмжээнд мөрдөхөөр боловсруулсан боловч тус баримт бичигт компанийн үйл ажиллагаатай холбоотой зарим ажил гүйлгээг хэрхэн бүртгэх, тайлагнах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна	1	-	-	-	1	-
10	МУЗГ-ын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэмд ахмадын сан байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох талаар тусгаагүй байна.	1	-	-	-	1	-
11	Компанийн өмчлөлд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр бүхий улсын дугаар ашиглаагүй байна.	1	-			1	-
Дүн		11	1,717,089.7	7	1,717,089.7	4	-
Нийт дүн		12	2,635,841.6	8	2,635,841.6	4	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 194/А0170433

Улаанбаатар хот

САГ -2026/100/НА -СТА -ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК-ийн Захиргаа удирдлагын газрын даргын албан тушаалд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 3 сарын туршилтын хугацаагаар томилогдсон албан хаагчид "Гүйцэтгэлийн удирдлагын журам"-д заасан аргачлалыг мөрдөөгүйгээс 6,396,825.00 /зургаан сая гурван зуун ерэн зургаан мянга найман зуун хорин таван/ төгрөгийн урамшуулал илүү олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай" 20.8-д "Ажил олгогч ажилтны үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр төлөвлөж, гүйцэтгэлийг сар, улирал, хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнд тохирсон цалин олгох ба энэ харилцааг Гүйцэтгэлийн удирдлагын журмаар зохицуулна", "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/112 тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн удирдлагын журам"-ын 4.9-д "Ажилтан урамшууллын хамрах хугацааны 30 хувиас дээш хугацаанд байгууллагад ажилласан бол ажилласан сараар гүйцэтгэлийн хувь тооцож урамшуулалд хамруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчид илүү олгосон үр дүнгийн урамшуулал 6,396,825.00 /зургаан сая гурван зуун ерэн зургаан мянга найман зуун хорин таван/ төгрөгийг тооцоолол хийсэн цалин хөлс, тэтгэмж, урамшуулал хариуцсан ахлах нягтлан бодогч Ч. Хүрэлбаатар, гүйлгээг хянасан бүртгэл тайлагналын хэлтсийн менежер, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэндэлгэр нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд буцаан төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/-д хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 195/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сахилгын шийтгэл ногдуулсан 9 ажилтанд нийт 63,477,500.00 /жаран гурван сая дөрвөн зуун далан долоон мянга таван зуун/ төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай" 22 дугаар зүйлийн 22.7-д "Сахилгын шийтгэл ногдуулсан хугацаанд урамшуулал, дэмжлэг олгогдохгүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад олгосон үр дүнгийн урамшуулал 63,477,500.00 /Жаран гурван сая дөрвөн зуун далан долоон мянга таван зуун/ төгрөгийг тооцоолол хийсэн цалин хөлс, тэтгэмж, урамшуулал хариуцсан ахлах нягтлан бодогч Ч. Хүрэлбаатар, гүйлгээг хянасан бүртгэл тайлагналын хэлтсийн менежер, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэндэлгэр нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд буцаан төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 20061-р хороо Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

АТА16087
9025081411

Z:\Akr\2026\0316 SAG-41.Docx

1526200317



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 930/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026 / 100 / НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК нь компанийн дүрэмдээ эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зээл олгох, зээл авах, зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулах, баталгаа болон батлан даалт гаргах эрхийг тусган батлуулсан бөгөөд орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай ажиллаж байгаа хараат болон охин компаниудад зээлийн санхүүжилт олгож, зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж, насжилт өндөртэй найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тус компани 2011 оноос хойш 11 охин, 1 хараат компанид нийт 142,414,426,833.35 /нэг зуун дөчин хоёр тэрбум дөрвөн зуун арван дөрвөн сая дөрвөн зуун хорин зургаан мянга найман зуун гучин гурван төгрөг гучин таван мөнгө/ төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөл бүхий зээлийн санхүүжилт олгож, үүнээс 35,297,269,178.75 /гучин таван тэрбум хоёр зуун ерэн долоон сая хоёр зуун жаран есөн мянга нэг зуун далан найман төгрөг далан таван мөнгө/ төгрөгийн хүүний авлага үүссэн байна. Мөн өмнөх жилүүдэд олгосон зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байхад тайлант онд дахин 6 компанид 18,666,096,682.58 /арван найман тэрбум зургаан зуун жаран зургаан сая ерэн зургаан мянга зургаан зуун наян хоёр төгрөг тавин найман мөнгө/ төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон, өмнөх аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол компани нь зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ", 84 дүгээр зүйлийн 84.4.2-д "Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хуулийн болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай хараат болон охин компаниудад зээлийн санхүүжилт олгож, зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж, насжилт өндөртэй найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бүрдүүлж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР АХЛАХ АУДИТОР АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ С.НАЦАГДОРЖ Э.БАТ-ЭРДЭНЭ Б.БАТХИШИГ
--	--	---



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 931/АДИ70433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд охин болон хараат компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн гэрээний хугацаа дууссан байхад зээлийн үндсэн төлбөр 15,540,226,517.96 /арван таван тэрбум таван зуун дөчин сая хоёр зуун хорин зургаан мянга таван зуун арван долоон төгрөг ерэн зургаан мөнгө/ төгрөг, хуримтлагдсан хүү 1,061,241,470.78 /нэг тэрбум жаран нэгэн сая хоёр зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун далан төгрөг далан найман мөнгө/ төгрөг, нийт 16,601,467,988.74 /арван зургаан тэрбум зургаан зуун нэг сая дөрвөн зуун жаран долоон мянга есөн зуун наян найман төгрөг далан дөрвөн мөнгө/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг аваагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх". Иргэний тухай хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1-д "зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдүүлэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрлийн, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хараат болон охин компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, хугацаандаа эргэн төлөгдөөгүйгээс үүссэн үндсэн төлбөрийн болон хүүний авлагыг барагдуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 932/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс монгол нэгдлийн хэмжээний хараат, охин компаниас зөвхөн 7 компанитай менежментийн үйлчилгээний гэрээ байгуулж, тайлант онд 3 компаниас 55,835,204,036.87 /тавин таван тэрбум найман зуун гучин таван сая хоёр зуун дөрвөн мянган гучин зургаан төгрөг наян долоон мөнгө/ төгрөгийн орлого бүрдүүлсэн нь нэгдлийн хэмжээний охин, хараат компаниудад менежментийн үйлчилгээг нэгдсэн байдлаар жигд, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлээгүй байна.

Мөн менежментийн төлбөрийн хувь, хэмжээ, өртөг тооцсон талаар нарийвчилсан тооцоололгүй, хувь хэмжээг ялгаатай тогтоосон, орлогын бүртгэлийн талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тодорхой тусгаагүй, борлуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг тооцож, хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.12-т "Толгой компани нь үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд хараат болон охин компанийн үйл ажиллагаанд зөвхөн эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээр оролцоно", 84 дүгээр зүйлийн 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэгдлийн хэмжээний охин, хараат компаниудад менежментийн үйлчилгээг нэгдсэн байдлаар жигд, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлдэггүй, орлогын бүртгэлийн талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тодорхой тусгаагүй, борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцож, хүлээн зөвшөөрч бүртгэдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 933/АД170433

Улаанбаатар хот

САГ - 2026 /100/НА -СТА -ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК нь гадаад дахь төлөөлөгчийн газруудын оффис, ажилтнуудын орон сууц, авто машины түрээсийн төлбөрийн норм, нормативыг тогтоогоогүй бөгөөд ашиглаж буй байрны талбай нь Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад мөрдөгддөг дундаж талбайн нормтой харьцуулахад талбайн хэмжээ илүү байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3-т "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрдэнэс Монгол ХХК нь гадаад дахь төлөөлөгчийн газруудын оффис, ажилтнуудын орон сууц, авто машины түрээсийн төлбөрийн норм, нормативыг тогтоогоогүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 934/АД170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолоор Эрдэнэс Ассет Менежмент ҮЦК ХХК-ийг техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаагүйгээр үүсгэн байгуулж, 2023 онд татан буулгасан бөгөөд 2019–2023 онд хуримтлагдсан 1,477,240,582.00 /нэг тэрбум дөрвөн зуун далан долоон сая хоёр зуун дөчин мянга таван зуун наян хоёр/ төгрөгийн зээлийн санхүүжилтийн авлага, 223,369,744.53 /хоёр зуун хорин гурван сая гурван зуун жаран есөн мянга долоон зуун дөчин дөрвөн төгрөг тавин гурван мөнгө/ төгрөгийн хүүний авлага, нийт 1,700,610,326.53 /нэг тэрбум долоон зуун сая зургаан зуун арван мянга гурван зуун хорин зургаан төгрөг тавин гурван мөнгө/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй, авлага барагдуулах талаар зохих арга хэмжээ аваагүй, авлагыг хэрхэн шийдвэрлэх талаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байхад 2024 оны санхүүгийн тайланд хуримтлагдсан ашиг (алдагдал)-ын дансанд хааж бүртгэсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Компанийг татан буулгах үед түүний өр төлбөрийг барагдуулахдаа Иргэний хууль, энэ хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө", 27.2-т "Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлэх бөгөөд нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байна", 27.3-т "Татан буулгах комисс нь компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг зээлдүүлэгчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй", 27.10-т "Татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн зээлдүүлэгчдийн өр төлбөрийг татан буулгах балансыг баталсан өдрөөс эхлэн тус балансын дагуу Иргэний хууль болон энэ хуульд заасан дарааллын дагуу барагдуулна", Иргэний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ", 32.6-д "Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална", 281 дүгээр зүйлийн 281.1-д "зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдүүлэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрлийн, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ", 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Эрдэнэс Монгол ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 8 дугаар тогтоолоор "Компани татан буулгах тухай" 02 дугаар хавсралт Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгах комиссын журмын 1-д "Татан буулгах комиссын өр төлбөр барагдуулах хугацаа 2 сар байна. Мөн тус журмын 5-д "Татан буулгах комисс нь компанийн бусдын өмнө хүлээсэн аливаа үүрэг, өр төлбөр, бусдаас авах авлага байвал хэрхэн шийдвэрлэх саналыг хувьцаа эзэмшигчид танилцуулж шийдвэр гаргуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зээлийн санхүүжилтийн авлагыг барагдуулаагүй, авлага барагдуулах талаар зохих арга хэмжээ аваагүй, авлагыг хэрхэн шийдвэрлэх талаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байхад хуримтлагдсан ашиг дансанд хааж бүртгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 935/АД170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 64 дүгээр хуралдааны тэмдэглэл, Эрдэнэс Монгол ХХК болон Эйкусора ХХК-ийн хооронд 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан гэрээг үндэслэн Эрдэнэс Шивээ Энержи ХХК, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 19 дүгээр тогтоол, Эрдэнэс Монгол ХХК болон МСХ Клиринг ХХК-ийн хооронд байгуулсан гэрээг үндэслэн Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийг тус тус үүсгэн байгуулсан байна.

Дээрх компаниудыг үүсгэн байгуулахдаа техник, эдийн засгийн үндэслэл, эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгааг боловсруулаагүй, байгуулагдсан цагаасаа эхлэн алдагдалтай ажилласан бөгөөд Эрдэнэс Монгол ХХК-аас олгосон зээлийн санхүүжилтийн 1,068,230,000.00 /нэг тэрбум жаран найман сая хоёр зуун гучин мянган/ төгрөгийн үндсэн зээлийн авлага, 536,786,112.00 /таван зуун гучин зургаан сая долоон зуун наян зургаан мянга нэг зуун арван хоёр/ төгрөгийн хуримтлагдсан хүүний авлага, нийт 1,605,016,112.00 /нэг тэрбум зургаан зуун таван сая арван зургаан мянга нэг зуун арван хоёр/ төгрөгийн авлагыг хэрхэн барагдуулах, эргэн төлүүлэх нь тодорхойгүй болж, найдваргүй авлага үүсэх эрсдэл бий болсон байна.

Мөн дээрх компаниудыг татан буулгах үүрэг, чиглэл өгсөн боловч татан буулгах комисс уг шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж, ямар шийдвэр гаргасан нь тодорхойгүй, анхан шатны баримт, материалын бүрдэл хангалтгүй, баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д "Дампуурсан буюу техник, технологи нь хоцрогдсон, цаашид өөрчлөн шинэчилсэн ч эдийн засгийн үр ашиггүй нь тогтоогдсон төрийн өмчит үйлдвэрийн газрыг Засгийн газрын шийдвэрээр татан буулгаж өрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг хувьчилж болно", Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компани татан буулгах комисс журмын дагуу ажиллаагүй, анхан шатны баримт, материалын бүрдэл хангалтгүй, холбогдох авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

[Handwritten signature]



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 936/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зээлийн санхүүжилтийн гэрээнд үндсэн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн төлөгдөөгүй үндсэн төлбөрийн дүнгээс гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд нэмэгдүүлсэн хүү тооцохоор заасан боловч хүү тооцоогүй байна.

Тайлант онд охин болон хараат гурван компанийн хугацаандаа төлөгдөөгүй нийт 15,121,033,321.96 /арван таван тэрбум нэг зуун хорин нэгэн сая гучин гурван мянга гурван зуун хорин нэгэн төгрөг ерэн зургаан мөнгө/ төгрөгийн үндсэн төлбөрт ногдох 756,360,006.86 /долоон зуун тавин зургаан сая гурван зуун жаран мянга зургаан төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийн нэмэгдүүлсэн хүүг тооцоогүй, холбогдох авлагыг бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", Иргэний тухай хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1-д "зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдүүлэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрлийн, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ", 453 дугаар зүйлийн 453.1-д "Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй", Зээлийн санхүүжилтийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.3-т "Зээлийн хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг төлөөгүй бол зээлийн хуваарьт өдрийн дараагаас эхлэн тухайн төлөөгүй үндсэн төлбөрийн дүнгээс гэрээний үүргээ биелүүлж дуусах хүртэлх хугацаанд гэрээнд заасан хувиар нэмэгдүүлсэн хүүг тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хараат болон охин компанитай байгуулсан гэрээнд заасан нэмэгдүүлсэн хүү тооцоогүй, гэрээний заалтыг мөрдөөгүй, гэрээний хугацаа дууссан байхад хэрэгжилтийг дүгнээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 937/АД170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА-СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны "Компанийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" 40 дүгээр тогтоолоор компанийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхардсан чиг үүрэг бүхий Хяналтын асуудал хариуцсан менежер, Чанар, бүтээмжийн асуудал хариуцсан менежер, Дижитал шилжилт хариуцсан менежер, Хариуцлагатай уул уурхайн асуудал хариуцсан менежерийн албан тушаалуудыг баталж, үндсэн цалинг 12,000,000.0 /арван хоёр сая/- 14,200,000.00 /арван дөрвөн сая хоёр зуун мянган/ төгрөгөөр тогтоосон, компанийн засаглал хариуцсан менежерийн албан тушаалыг шинээр бий болгож, үндсэн цалинг 14,000,000.00 /арван дөрвөн сая/ төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд нийт 1,073,044,792.00 /нэг тэрбум далан гурван сая дөчин дөрвөн мянга долоон зуун ерэн хоёр/ төгрөгийн цалин, нэмэгдэл олгосон нь компанийн бүтэц зохион байгуулалт уялдаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.2. чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн бүтэц зохион байгуулалттай уялдаагүй, удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхардсан чиг үүрэг бүхий менежерүүдийг томилж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



1526181661



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 938/АД170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/МА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн нарийн бичгийн даргын нийт 3 удаагийн албан бичгийг үндэслэн гадаад албан томилолтын онгоцны билетийн зардалд 70,835,300.00 /далан сая найман зуун гучин таван мянга гурван зуун/ төгрөг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2 зөвлөхийн гадаад албан томилолтын зардалд 12,825,625.20 /арван хоёр сая найман зуун хорин таван мянга зургаан зуун хорин таван төгрөг хорин мөнгө/ төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дүрмийн 12 дугаар зүйлийн 12.3-т "Төрийн албан хаагчийн хувьд Хэрэг эрхлэх газарт харьяалагдах улс төрийн албан тушаалтны дотоод, гадаад албан томилолтын асуудлыг Хэрэг эрхлэх газрын дарга шийдвэрлэнэ", Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.11.22-ны өдрийн А/126 тушаалаар баталсан "Эрдэнэс Монгол ХХК-ийн ажилтнуудын албан томилолтоор ажиллах журам"-ын 2.1.4-т "Ажилтан" гэж компанид хөдөлмөрийн гэрээгээр үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тухайн компанид хамааралгүй албан хаагчдад холбогдох хууль, журам зөрчин томилолтын зардал олгож байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ

9006109
АГА16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 939/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 29,000,000.00 /хорин есөн сая/ төгрөг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, ажлын албаны хурал зөвлөгөөний ажлын хэрэгцээнд 16,554,985.00 /арван зургаан сая таван зуун тавин дөрвөн мянга есөн зуун наян таван/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттай зохион байгуулах”, 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4 “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” -д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин бэлэг дурсгалын зүйл худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 940/АД170433

Улаанбаатар хот

САГ -2026/100/НА - СТА -ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлахтай холбоотой ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн 4 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 111,122,450.00 /нэг зуун арван нэгэн сая нэг зуун хорин хоёр мянга дөрвөн зуун тавин/ төгрөгийг компаниас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, тайлант онд нэмж 8 ажилтанд 350,897,025.00 /гурван зуун тавин сая найман зуун ерэн долоон мянга хорин таван/ төгрөгийг компаниас олгож, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 4.2.9. энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын хохирлыг байгууллагаас төлснийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх арга хэмжээ авч, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Эрсдэлийн удирдлага, хяналтын газрын дарга /Л.Наранчимэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 941/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компанийн хараат болон охин компаниуд нь төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилготой ч дийлэнх нь алдагдалтай, үр ашиггүй ажиллаж, шинээр охин компаниуд нэмж байгуулах зэргээр төрийн өмчийн үр ашгийг бууруулж байна. Мөн тус компани нь эдийн засгийн үр ашиг нь хэзээ гарах нь тодорхойгүй, байгуулагдсан цагаасаа алдагдалтай ажиллаж байгаа компаниудад үр ашгийн шинжилгээ хийгээгүй, алдагдалтай ажилласан шалтгаан нөхцөлийг тодорхойлоогүй, алдагдлыг бууруулах, компаниудыг нэгтгэх, татан буулгах зэрэг арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21^{1.11}-д "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах саналыг Засгийн газарт хүргүүлнэ"-ийн 1-д "энэ хуулийн 21¹ дүгээр зүйлийн 3¹-д заасны дагуу эцэслэн тохирсон зорилтын саналын хэрэгжилт гурван жил дараалан хангалтгүй гэж дүгнэгдсэн", 2-т "үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд гурван жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анх байгуулагдсанаас хойш алдагдалтай ажиллаж байгаа хараат болон охин компаниудад үр ашгийн шинжилгээ хийгээгүй, алдагдалтай ажилласан шалтгаан нөхцөлийг тодорхойлоогүй, алдагдлыг бууруулах, компаниудыг нэгтгэх, татан буулгах зэрэг арга хэмжээ авдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 942/АД170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТӨҮТ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус компанийн батлагдсан төсөв, тухайн жилийн зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлбар, хагас жилийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайлант хугацаанд 5 сая төгрөгөөс дээш гэрээний дүн бүхий нийт 918,751,952.00 /есөн зуун арван найман тэрбум долоон зуун тавин нэгэн мянга есөн зуун тавин хоёр/ төгрөгийн худалдан авалтын мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 4.1.1-д "худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар", 4.1.2-т "төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар", 4.1.8-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 -д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 943/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор компанийн 2025 оны төсвийг баталсан бөгөөд "Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг" холбогдох хууль болон журамд заасан цаглабарт хугацаанаас хоцроож, гүйцэтгэх захирлын 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1-д "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна", 2.6-д "Захиалагч төрийн байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага төлөвлөгөөг батлагдсан төсөв болон хуульд нийцсэн эсэхийг хянан баталж, санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох дээд шатны байгууллагад төлөвлөгөөг цахим системээр илгээнэ", 2.8-д "Энэ журмын 1.7-д заасан захиалагчийн гүйцэтгэх удирдлага төлөвлөгөөг батлагдсан төсөв болон хуульд нийцсэн эсэхийг хянан, батална. Захиалагчийн баталгаажуулсан төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор цахим системд нийтэлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахдаа хуульд заасан цаглабарт хугацааг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 944/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 98,900,000.00 /ерэн найман сая есөн зуун мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй сургалтуудыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Мөн сургалтыг төлөвлөхдөө байгууллагын хэрэгцээ, шаардлагыг эрэмбэлж үнэлээгүй, хэрэгжүүлсэн сургалтын үр дүн, өгөөжийг тооцоогүй, төлөвлөгөөнд тусгаагүй 54,490,000.00 /тавин дөрвөн сая дөрвөн зуун ерэн мянган/ төгрөгийн 6 сургалтыг тайлант хугацаанд зохион байгуулж, ижил төрлийн сургалтуудын төсвийг хуваан шууд худалдан авалтын аргаар гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", "Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сургалтын хэрэгцээ, шаардлагыг эрэмбэлэн үнэлээгүй, компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй сургалтуудыг шууд гэрээ байгуулан худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 945/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026 / 100 / ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 876,639,980.00 /найман зуун далан зургаан сая зургаан зуун гучин есөн мянга есөн зуун наян/ төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэн батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 946/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 44 төсөл арга хэмжээнд гэрээний нийт дүнгээр 560,449,688.00 /таван зуун жаран сая дөрвөн зуун дөчин есөн мянга зургаан зуун наян найман/ төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Мөн тайлант онд он дамжин хэрэгжиж буй зарим төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна." 3-т "Тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 947/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА -СТА -ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 280,000,000.00/хоёр зуун наян сая/ төгрөгөөр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах төсөл, арга хэмжээний төлөвлөгөө баталсан боловч төлөвлөгөөнд туссан төсөвт өртгөөс хэтрүүлж тайлант онд 41 хэвлэл, мэдээллийн байгууллагатай 424,370,000.00 /дөрвөн зуун хорин дөрвөн сая гурван зуун далан мянган/ төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 484,278,200.00 /дөрвөн зуун наян дөрвөн сая хоёр зуун далан найман мянга хоёр зуун/ төгрөгийг зарцуулсан байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх ажлын даалгаврыг боловсруулахдаа төсвийн тооцоолол хийлгүйгээр ерөнхий байдлаар боловсруулж гэрээний үнийг 4,900,000.00 /дөрвөн сая есөн зуун мянга/-19,800,000.00 /арван есөн сая найман зуун мянган/ төгрөгийн дүнтэйгээр нийтлэг байдлаар байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.1-д “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хэвсрэлтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх ажлын даалгаврыг боловсруулахдаа төсвийн тооцоолол хийлгүйгээр ерөнхий байдлаар боловсруулж гэрээний үнийн дүнг нийтлэг байдлаар тогтоосон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан нийт төсөвт өртгийн дүнгээс илүү дүнгээр гэрээ байгуулж, гүйцэтгэл гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ

9006109
ATA16087
9025081411





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 948/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шууд худалдан авалтын аргаар худалдан авсан зарим бараа, ажил, үйлчилгээ нь ажлын даалгаваргүй, техникийн тодорхойлолтгүй, хүлээн авсан комиссын болон гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Мөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг нарийвчлан боловсруулахгүйгээр ерөнхий байдлаар боловсруулдаг, зарим гэрээнд гэрээний үнийн дүнг тодорхой тусгадаггүй, гэрээ дүгнэсэн актад гэрээнд заасан шалгуурууд болон актаар хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээний хугацаа, нэр төрлийн талаар нарийвчлан тодорхой тусгалгүйгээр дүгнэдэг зэрэг нь талуудын гэрээний хариуцлага алдагдах, төлөвлөсөн төсвийг хэтрүүлэн зарцуулах, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгааг илтгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана", 12.2-т "Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно" 39 дүгээр зүйлийн 39.3.1-д "гэрээний үнэ", Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1-д "Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ", 344 дүгээр зүйлийн 344.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно", 344.2-т "Ажил гүйцэтгэсний хөлсийг талууд тохиролцоогүй боловч гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал зэргээс шалтгаалан захиалагч тухайн төрлийн ажил гүйцэтгэхэд мөрддөг эрх бүхий байгууллагаас баталсан жишиг үнэлгээний жагсаалт байвал тухайн жагсаалтыг үндэслэн, тийм жагсаалт байхгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлс төлнө" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим төсөл, арга хэмжээг ерөнхий байдлаар боловсруулсан, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 949/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн “Компанийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах, үйл ажиллагаандаа ашигладаггүй 8,715,985,215.23 /найман тэрбум долоон зуун арван таван сая есөн зуун наян таван мянга хоёр зуун арван таван төгрөг хорин гурван мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй нүүрс экспортлох гаалийн үзлэгийн зориулалттай 33 402 м2 бетон хучилттай үзлэгийн зам талбайг санхүүгийн тайланд тусгаж хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй, мөн Гашуунсухайт авто замыг дагасан боомтын дэд бүтцийн 28 нэр төрлийн 2,978,635,894.46 /хоёр тэрбум есөн зуун далан найман сая зургаан зуун гучин таван мянга найман зуун ерэн дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж зөвшөөрөл авахгүй нурааж, цаашид ашиглах боломжгүй болгосон” зөрчлийг арилгах тухай аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 67.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1 “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 950/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026/100/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, үүрэгт ажлаас нь чөлөөлөх тушаалын дагуу өмнөх гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ажлаас чөлөөлж, 8 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 96,000,000.00 /ерэн зургаан сая/ төгрөгийг тэтгэмжийг олгохдоо ажилтнаас авах 16,155,844.14 /арван зургаан сая нэг зуун тавин таван мянга найман зуун дөчин дөрвөн төгрөг арван дөрвөн мөнгө/ төгрөгийн авлагыг суутгаагүй” зөрчлийг арилгах аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаа нь өмнө хянан баталгаажуулах”, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 951/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026 /100/НА - СТА - ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн хавсралтад дурдсан албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”, 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.2-т “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй бүртгэл тайлагналын хэлтсийн менежер, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэндэлгэрт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Лаваадалайд/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Даваадалай/, Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Зоригтбат/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Э.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАТХИШИГ

Хавсралт-1

№	Албан шаардлагын			Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Албан шаардлагыг даалгасан ажилтны нэрс
	Огноо	Дугаар	Хэрэгжүүлэх хугацаа			
1	2025-04-14	930/АО150460	2025-09-01	Компанийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах, үйл ажиллагаандаа ашигладаггүй 8,716.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй нүүрс экспортлох гаалийн үзлэгийн зориулалттай 33,402 м2 бетон хучилттай үзлэгийн зам талбайг санхүүгийн тайланд тусгаж хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй, мөн Гашуунсухайт авто замыг дагасан боомтын дэд бүтцийн 28 нэр төрлийн 2,978.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж зөвшөөрөл авахгүй нурааж, цаашид ашиглах боломжгүй болсон байна.	11,694,621.1	Гүйцэтгэх захирал /С.Наранцогт/, нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга /Б.Батбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/,
2	2025-04-14	932/АО150459	2025-09-01	Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, үүрэгт ажлаас нь чөлөөлөх тушаалын дагуу өмнөх гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ажлаас чөлөөлж, 8 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 96.0 сая төгрөгийн тэтгэмжийг олгохдоо ажилтнаас авах 16.2 сая төгрөгийн авлагыг суутгаагүй байна.	16,156.0	Гүйцэтгэх захирал /С.Наранцогт/, нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга /Б.Батбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/,
3	2025-04-14	935/АО150458	2025-09-01	Засгийн газрын 108 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэм”-ийн 3.5.9-д заасны дагуу нэгдлийн охин компаниудад зээлийн санхүүжилт олгохдоо зээлийн эргэн төлөх бололцоог нь үнэлээгүй, эрсдэлийн үнэлгээний дүн шинжилгээ хийлгүй 2016 оноос өнөөг хүртэл 11-14 хувийн хүүтэй, 1-2 жилийн хугацаатай зээл олгож, нийт 164,932.4 сая төгрөгийн авлага хуримтлуулан бүртгэсэн байгаа нь цаашид /Багануур ХК, Мон-Атом ХХК, Монгол-ГБҮ ХХК, Монголын Эрдэс Баялагийн бирж ХХК, Шивээ овоо ХК, Эрдэнэс газ төсөв, Эрдэнэс Метан ХХК, Эрдэнэс Оюу Толгой ХХК, Эрдэнэс ҮТП ХХК, Эрдэнэс Шивээ Энержи ХХК/ компаниудыг ашиг орлогоо нэмэгдүүлэх, зардлаа хэмнэх идэвх оролцоог сулруулах эрсдэлийг бий болгож байна. Мөн зээлийн санхүүжилтийн гэрээний хэрэгжилт, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьдаггүй, зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйгээс хугацаа хэтэрсэн байна.	164,932,442.9	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дарга /Д.Нацагдорж/, Гүйцэтгэх захирал /С.Наранцогт/, нэгдсэн стратеги, санхүүгийн удирдлагын газрын дарга /Б.Батбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Д.Нацагдорж/
4	2025-04-14	936/АО150458	2025-09-01	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай 21, 56 дугаар тогтоолуудыг үндэслэн чөлөөлөгдсөн 13 ажилтанд Улсын	111,122.5	Гүйцэтгэх захирал /С.Наранцогт/, нэгдсэн стратеги, санхүүгийн

			дээд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан 591.7 сая төгрөгийг нөхөн олговор олгохоор шийдвэрлэснээс онд 4 ажилтанд компаниас нийт 111.1 сая төгрөг төлснийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр авлага үүсгэж бүртгээгүй байна.		удирдлагын газрын дарга /Б.Батбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Б.Цэрэндэлгэр/, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Д.Нацагдорж/
Нийт дүн				176,754,342.5	